



МОНГОЛ УЛСЫН САНХҮҮГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТАЙЛАН

2016
VI сар
№7

МОНГОЛ УЛСЫН САНХҮҮГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТАЙЛАН

Дугаар №7

Улаанбаатар хот
2016 оны 6 дугаар сар

АГУУЛГА

ӨМНӨХ ҮГ	7
ТОЙМ	9
1. МАКРО-САНХҮҮГИЙН ОРЧИН	14
1.1 ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ	14
• Дэлхийн эдийн засаг	14
• Дэлхийн санхүүгийн зах зээл	18
1.2 МОНГОЛ УЛСЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ	21
• Монгол улсын эдийн засгийн төлөв байдал	21
• Гадаад сектор	27
• Бодит сектор	32
• Мөнгө санхүүгийн сектор	33
• Улсын төсөв	36
2. САНХҮҮГИЙН САЛБАР, ТҮҮНИЙ ДАРХЛАА	40
2.1 БАНКНЫ САЛБАРЫН ТӨЛӨВ БАЙДАЛ	40
• Банкны салбар	40
• Макро зохистой бодлого, түүний хэрэгжилт	48
2.2 БАНКНЫ БУС САНХҮҮГИЙН САЛБАРЫН ТӨЛӨВ БАЙДАЛ	50
• Банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоо	50
• Хөрөнгийн зах зээл	54
• Даатгалын байгууллага	57
• Зээлийн батлан даалтын үйлчилгээ үзүүлэгч байгууллага	58
• Хөдөө аж ахуйн бирж ба түүхий эдийн арилжаа	59
3. САНХҮҮГИЙН САЛБАРЫН ДЭД БҮТЭЦ, ТҮҮНИЙ ИНСТИТУЦИ	60
3.1 ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИНД ГАРСАН ӨӨРЧЛӨЛТ	60
3.2 ТӨЛБӨР ТООЦОО, ХӨРӨНГИЙН БҮРТГЭЛИЙН СИСТЕМ	60
3.3 САНХҮҮГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА	63

ДҮРСЛЭЛҮҮД

Дүрслэл Т.1	Монгол Улсын санхүүгийн тогтвортой байдлын зураглал	12
Дүрслэл 1.1	Дэлхийн эдийн засгийн өсөлтийн төсөөлөл	14
Дүрслэл 1.2	АНУ-ын зарим голлох үзүүлэлтүүд	15
Дүрслэл 1.3	Евро бүсийн ажилгүйдлийн түвшин	15
Дүрслэл 1.4	БНХАУ-ын нүүрсний импорт	16
Дүрслэл 1.5	Бүтээгдэхүүн, түүхий эдийн үнэ	17
Дүрслэл 1.6	Зарим хөрөнгийн захын индекс	18
Дүрслэл 1.7	Шанхайн хөрөнгийн биржийн индекс	18
Дүрслэл 1.8	Зарим хөгжингүй орнуудын Засгийн газрын 10 жилийн хугацаатай бондын өгөөж	19
Дүрслэл 1.9	Голлох валютуудын ам.доллартай харьцах ханш	19
Дүрслэл 1.10	Зэсийн үнэ ба ам.долларын ханшийн индекс	20
Дүрслэл 1.11	Төлбөрийн тэнцлийн алдагдал	21
Дүрслэл 1.12	Гадаадын шууд хөрөнгө оруулалт	21
Дүрслэл 1.13	Импортын жилийн өсөлт	22
Дүрслэл 1.14	Монгол Улсын улирлын ДНБ-ий жилийн өсөлт	23
Дүрслэл 1.15	Гадаад, дотоод цэвэр актив ба М2 мөнгө	23
Дүрслэл 1.16	Засгийн газрын үнэт цаасны хүү	24
Дүрслэл 1.17	Төсөв болон мөнгөний бодлогын хүрээнд эдийн засагт хийгдсэн санхүүжилтийн бүтэц ба эдийн засгийн өсөлт	24
Дүрслэл 1.18	Инфляцийн задаргаа	25
Дүрслэл 1.19	Санхүүгийн мөчлөг	26
Дүрслэл 1.20	Төлбөрийн тэнцлийн гүйцэтгэл	27
Дүрслэл 1.21	Урсгал тэнцлийн бүтэц	27
Дүрслэл 1.22	Урсгал тэнцлийн санхүүжилт	27
Дүрслэл 1.23	Хөрөнгө, санхүүгийн дансны бүтэц	28
Дүрслэл 1.24	Гадаад худалдааны нөхцөлийн индекс	28
Дүрслэл 1.25	Нийт экспорт	29
Дүрслэл 1.26	Нийт импорт	29
Дүрслэл 1.27	Гадаад валютын ханш	29
Дүрслэл 1.28	Гадаад валютын нөөц	30
Дүрслэл 1.29	Гадаад зах зээлд гаргасан Монгол Улсын Засгийн газрын бондын үнэ	30
Дүрслэл 1.30	Эдийн засгийн өсөлтийн задаргаа	32
Дүрслэл 1.31	М2 мөнгөний бүтэц	33
Дүрслэл 1.32	М2 мөнгөний жилийн өсөлтийн задаргаа	33
Дүрслэл 1.33	Мөнгөний үзүүлэлтүүдийн ерөнхий бүтэц ба хандлага	34
Дүрслэл 1.34	Мөнгөний нийлүүлэлт ба мөнгөний үржүүлэгч	34
Дүрслэл 1.35	Банкуудын хадгаламж болон зээлийн хүү	34
Дүрслэл 1.36	Банк хоорондын захын хүү	35
Дүрслэл 1.37	Банк хоорондын захын хүүний хэлбэлзэх интервал	35
Дүрслэл 1.38	Нэгдсэн төсвийн орлого, зарлагын гүйцэтгэлийн жилийн өөрчлөлт	37
Дүрслэл 1.39	Нэгдсэн төсвийн тэнцлийн гүйцэтгэл	38
Дүрслэл 1.40	Засгийн газрын бонд ба зээл	38
Дүрслэл 1.41	Засгийн газрын богино ба урт хугацаат бондын арилжаа	39

Дүрслэл 2.1	Банкны салбарын активын бүтэц	40
Дүрслэл 2.2	Банкны салбарын пассивын бүтэц	40
Дүрслэл 2.3	Банкны салбарын эх үүсвэрийн жилийн өсөлт	41
Дүрслэл 2.4	Банкны салбарын актив, зээлийн жилийн өсөлт	41
Дүрслэл 2.5	Олгосон зээлийн жилийн өсөлт	41
Дүрслэл 2.6	Салбаруудын зээлийн төвлөрөл	42
Дүрслэл 2.7	Зээлийн чанарын үзүүлэлт, салбараар	42
Дүрслэл 2.8	Хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн өсөлт	42
Дүрслэл 2.9	Хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээл, валютын төрлөөр	43
Дүрслэл 2.10	Өрхийн бодит орлогын өсөлт	43
Дүрслэл 2.11	Өрхийн орлого, зарлагын харьцаа	43
Дүрслэл 2.12	Өрхийн өрийн дарамт	44
Дүрслэл 2.13	Өрхийн өр, орлогын харьцаа	44
Дүрслэл 2.14	Хувийн салбарын өрийн дарамт	44
Дүрслэл 2.15	Орон сууцны үнэ, ипотекийн зээлдэгчдийн тооны өсөлт	45
Дүрслэл 2.16	Өөрийн хөрөнгийн үзүүлэлтүүд	45
Дүрслэл 2.17	Банкны актив болон өөрийн хөрөнгийн өгөөж	45
Дүрслэл 2.18	Зээлийн эрсдэлийн сангийн өсөлт	46
Дүрслэл 2.19	Банкны салбарын актив, пассив гарсан өөрчлөлт	46
Дүрслэл 2.20	Банкны салбарын төлбөр түргэн гүйцэтгэх чадвар	47
Дүрслэл 2.21	Хөрвөх чадварын үзүүлэлтүүд	47
Дүрслэл 2.22	Зээл, хадгаламжийн харьцаа	47
Дүрслэл 2.23	Бүртгэлтэй банк бус санхүүгийн байгууллагын тоо	50
Дүрслэл 2.24	Банк бус санхүүгийн байгууллагын нийт хөрөнгийн бүтэц	51
Дүрслэл 2.25	Банк бус санхүүгийн байгууллагын нийт зээл, зээлийн чанар	51
Дүрслэл 2.26	Хадгаламж, зээлийн хоршоо болон гишүүдийн тоо	53
Дүрслэл 2.27	Хадгаламж, зээлийн хоршоодын нийт зээл, зээлийн чанар	53
Дүрслэл 2.28	Хадгаламж, зээлийн хоршоодын өр төлбөр ба өөрийн хөрөнгө	54
Дүрслэл 2.29	ТОП-20 индекс болон зах зээлийн үнэлгээ	54
Дүрслэл 2.30	Бүртгэлтэй хувьцаат компанийн тоо	55
Дүрслэл 2.31	Даатгалын компаниудын өр төлбөр, эзэмшигчдийн өмч	58
Дүрслэл 2.32	Батлан даалт гаргасан байдал болон санхүүжилтийн эх үүсвэр	59
Дүрслэл 3.1	Их дүнтэй төлбөр тооцооны системийн нэг өдрийн дундаж үзүүлэлт	61
Дүрслэл 3.2	Бага дүнтэй төлбөр тооцооны системийн нэг өдрийн дундаж үзүүлэлт	62
Дүрслэл 3.3	Картын гүйлгээний нэг өдрийн дундаж үзүүлэлт	62

ХҮСНЭГТҮҮД

Хүснэгт Т.1	Монгол Улсын макро эдийн засаг, санхүүгийн салбарын голлох үзүүлэлтүүд	10
Хүснэгт 1.1	Төсвийн орлогын тасралт	23
Хүснэгт 1.2	Урсгал тэнцлийн алдагдлын санхүүжилт	28
Хүснэгт 1.3	Монгол Улсын нийт гадаад өр	30
Хүснэгт 1.4	Монгол Улсын зээлжих зэрэглэлийн өөрчлөлт	31
Хүснэгт 1.5	Бодит салбарын үндсэн үзүүлэлтүүд	32
Хүснэгт 1.6	2016 оны I улирлын байдлаарх бодит ДНБ-ий өсөлт	32
Хүснэгт 1.7	Нэгдсэн төсвийн орлогын төлөвлөгөө ба гүйцэтгэл	36
Хүснэгт 1.8	Нэгдсэн төсвийн орлогын гүйцэтгэл	36
Хүснэгт 1.9	Нэгдсэн төсвийн зарлагын төлөвлөгөө ба гүйцэтгэл	37
Хүснэгт 2.1	Банк бус санхүүгийн байгууллагын голлох статистик үзүүлэлтүүд	50
Хүснэгт 2.2	Банк бус санхүүгийн байгууллагын эрхэлж буй үйл ажиллагааны төрөл	51
Хүснэгт 2.3	Банк бус санхүүгийн байгууллагын санхүүгийн голлох үзүүлэлтүүд	52
Хүснэгт 2.4	Орлого, зарлага, ашигт ажиллагаа	52
Хүснэгт 2.5	ББСБ-уудын зохистой харьцааны үзүүлэлтүүд	52
Хүснэгт 2.6	Хадгаламж, зээлийн хоршоодын голлох статистик	53
Хүснэгт 2.7	Даатгалын салбарын тусгай зөвшөөрөл, эрх эзэмшигчдийн тоо	57
Хүснэгт 2.8	Даатгалын компаниудын нийт хөрөнгийн хэмжээ	57
Хүснэгт 2.9	Хөдөө аж ахуйн бирж дээрх түүхий эдийн үнийн дүн	59

ШИГТГЭЭНҮҮД

Шигтгээ 1:	Монгол Улсын санхүүгийн мөчлөг	26
-------------------	--------------------------------	----

ӨМНӨХ ҮГ

Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөс “Монгол Улсын санхүүгийн тогтвортой байдлын тайлан”-г хагас жил тутам олон нийтэд танилцуулдаг бөгөөд долоо дахь дугаарыг та бүхэнд өргөн барьж байна.

Хөгжингүй орнуудын эдийн засгийн өсөлт сул хэвээр, зах зээлд тодорхой бус байдал үргэлжилж, дэлхийн зах зээл дээрх газрын тос, бусад түүхий эдийн үнийн уналтаас улбаатай бүрэлдэж буй эдийн засагтай улс орнуудын эдийн засгийн өсөлтийн удаашралын нөлөөгөөр дэлхийн эдийн засаг, санхүүгийн тогтвортой байдалд учирч болзошгүй эрсдэл нэмэгдсээр байна.

Монгол Улсын хувьд гадаад сектороос ирэх сөрөг нөлөөлөл, төлбөрийн тэнцлийн шокийн эдийн засагт үзүүлэх нөлөөг зөөлрүүлэх чиглэлээр сүүлийн жилүүдэд макро эдийн засагт тохиргоо хийх бодлогын арга хэмжээг хэрэгжүүлсээр ирсэн. Дэлхийн зах зээл дээрх эрдэс, түүхий эдийн үнэ унаж, үүнийг даган манай улсын уул уурхайн салбарт хийгдэх гадаадын шууд хөрөнгө оруулалт үлэмж буурсан сүүлийн жилүүдэд дотоодын эдийн засагт үүсээд байсан илүүдэл эрэлт хумигдан төлбөрийн тэнцлийн нийт алдагдал тодорхой хэмжээгээр буурч эдийн засгийн гадаад тэнцвэр хангагдах нөхцөл бүрдлээ.

Хэдий тийм боловч эдийн засагт дотоод эрэлт хумигдснаар бодит эдийн засгийн өсөлт 2014 онд 7.9 хувь, 2015 онд 2.3 хувь байсан бол 2016 оны нэгдүгээр улиралд 3.1 хувьд хүрчээ. Эдийн засгийн өсөлтийн хурд ийнхүү саарч, дотоодын эдийн засаг гадаад зах зээлээс өндөр хамааралтай байсаар байгаа нь манай улсын санхүүгийн салбар, түүний тогтвортой

байдалд эрсдэл, сорилтыг нэгэн зэрэг авчирч байна.

Санхүүгийн салбар нь эдийн засагт хөрөнгийн хуваарилалтыг хийх гол судас төдийгүй итгэлцэл дээр оршин тогтнодог эмзэг бүтэц тул түүний тогтвортой байдал нь санхүүгийн зах зээлд оролцогчдын үнэн зөв мэдээлэлд үндэслэсэн бодитой хүлээлт, үйлдлээс ихээхэн хамааралтай байдаг. Тиймээс Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл нь Монгол Улсын санхүүгийн тогтолцоо, түүний тогтвортой байдлыг хангах үндсэн чиг үүргийнхээ хүрээнд санхүү, эдийн засгийн бодлогын асуудлыг тогтмол авч хэлэлцэхийн зэрэгцээ, олон нийтэд хүргэж буй мэдээллийн чанарыг сайжруулах, санхүүгийн талаарх иргэдийн суурь мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх зорилгоор “Санхүүгийн тогтвортой байдлын тайлан”-г тогтмол боловсруулан нийтэлсээр байна.

Санхүүгийн тогтвортой байдал нь системийн эрсдэлийг бууруулахад чиглэсэн макро зохистой арга хэмжээнээс гадна уламжлалт макро эдийн засгийн бодлого, санхүүгийн салбарын хяналт шалгалт, зохицуулалт, институцийн оновчтой тогтолцоо, тэдгээрийн харилцан уялдаат байдал зэргээс хамаардаг өргөн цар хүрээтэй ойлголт юм. Иймд бид “Санхүүгийн тогтвортой байдлын тайлан”-г боловсруулахдаа олон нийтэд албан ёсны эх сурвалж, статистикт үндэслэсэн нийт макро эдийн засаг, санхүүгийн салбарын нөхцөл байдал, хандлагын талаар харилцан уялдаа бүхий бодитой мэдээлэл өгөх зарчмыг баримталж байна.

Энэхүү тайлангийн агуулгыг цаашид сайжруулахад уншигч таны оролцоо, хувь

нэмэр ихээхэн үнэ цэнтэй тул энэхүү тайлантай холбогдох аливаа саналаа Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн ажлын албанд хаяглан, fsc@mongolbank.mn цахим шуудангаар ирүүлж болно. Таны саналыг хүлээж авахдаа бид үргэлж таатай байх болно.

ТОЙМ

Голлох түүхий эдийн үнэ цаашид үргэлжлэн буурах, хөрөнгийн дотогшлох урсгал саарах зэргээс шалтгаалан хөгжиж буй орнуудын эдийн засгийн өсөлт сул хэвээр байх төлөвтэй байгаа тул ОУВС-гийн шинжээчид дэлхийн эдийн засгийн өсөлтийн төсөөллийг 2015 оны 10 дугаар сард хийсэн төсөөллөөс 0.4 нэгж хувиар бууруулж 2016 онд 3.2 хувь, 2017 онд 0.3 нэгж хувиар бууруулж 3.5 хувьтай байхаар тус тус таамаглажээ.

АНУ-ын эдийн засгийн өсөлт 2015 онд 2.4 хувь, 2016 оны эхний улиралд 0.8 хувийн өсөлттэй гарлаа. Тус улсын ДНБ-ий 70 хувийг бүрдүүлэгч хувийн хэрэглээ 1.9 хувиар, засгийн газрын зардал 1.2 хувиар, орон сууцны салбарын хөрөнгө оруулалт 17.1 хувиар өсч, бизнесийн салбарын хөрөнгө оруулалт -6.2 хувиар буурснаар эдийн засгийн өсөлт 0.8 хувийн гүйцэтгэлтэй гарсан.

Евро бүсийн эдийн засаг 2015 онд 1.8 хувиар өссөн бол 2016 оны эхний улиралд 1.6 хувиар өслөө. Газрын тосны хямд үнэ болон мөнгөний уламжлалт бус тэлэх бодлого дотоод эрэлтийг дэмжиж, 2015 онд дунджаар 1.6 хувийн өсөлттэй байсан хэрэглээний зардал 2016 оны нэгдүгээр улиралд 1.5 хувиар өссөн бол экспорт, хөрөнгө оруулалтын өсөлт өмнөх улирлын өсөлтөөс харгалзан 0.5, 1 нэгж хувиар саарсан нь эдийн засгийн өсөлт буурахад хүргэжээ. Цаашид Грекийн өрийн хямрал, цагаачдын асуудал, Их Британи Европын Холбооноос гарах (Brexit) зэрэг улс төрийн тодорхой бус байдал хэвээр байгаа нь бүсийн өсөлтөд сөргөөр нөлөөлөхөөр байна.

Хятадын эдийн засаг 2015 онд 6.9 хувиар өссөн бол энэ оны эхний улиралд 6.7 хувиар өслөө. Тус улсын хөрөнгийн зах уналтанд орж, хөрөнгө гадагшлах урсгал нэмэгдсэн, үйлчилгээний салбарын өсөлт өмнөх улирлын өсөлтөөс 0.6 нэгж хувиар саарсан нь үүнд голчлон нөлөөлжээ. ОУВС-гийн төсөөллөөр Хятадын эдийн засаг энэ оны эцэст 6.5 хувиар, 2017 онд 6.2 хувиар тус тус өсөхөөр байна.

Манай улсын экспортын гол бүтээгдэхүүний нэг болох зэсийн дэлхийн зах зээл дээрх эрэлт сул, илүүдэл нийлүүлэлттэй байгаа нь дотоодын эдийн засагт урт хугацаанд сөрөг нөлөөлөл үзүүлэхээр байна. Улирлын онцлог, дэлхийн зах зээл дээрх үнийн бууралтаас үүдэн 2016 оны эхний хагаст БНХАУ зэсийн нөөцөө нэмэгдүүлж эхэлсэн нь богино хугацаанд зэсийн үнэ тогтворжиход нөлөөлөв. Хэдий тийм ч урт хугацаанд нийлүүлэлт эрэлтээс давсан хэвээр байгаа тул зэсийн үнэ төдийлөн огцом өсөх хандлагагүй хэмээн олон улсын шинжээчид үзэж байна. Харин нэг унц алтны үнэ 2015 оны эцэст 1,061 ам.долларт хүрч буурсан бол Холбооны Нөөцийн Банк мөнгөний бодлогоо хатууруулж бодлогын хүүгээ өсгөх хүлээлттэй байгаа нь алтны үнэ сэргэхэд нөлөөлж 2016 оны 6 дугаар сард 1,298 ам.долларт хүрч өсчээ.

Монгол Улсын эдийн засгийн бодит өсөлт 2012 оны 12.3 хувиас 2013 онд 11.6 хувь, 2014 онд 7.8 хувь, 2015 онд 2.3 хувь, 2016 оны эхний улиралд 3.1 хувь болж саарав. Гадаад активын огцом бууралтын сөрөг нөлөөг зөөлрүүлэх зорилгоор 2013-2014 онд мөнгөний уламжлалт бус бодлогын хүрээнд хийсэн мөнгөний нийлүүлэлт нь дотоод

активыг тогтворжуулж, эдийн засгийг богино хугацаанд (2013 онд) огцом агшихаас сэргийлсэн.

Монгол Улсын төлбөрийн тэнцлийн 2016 оны эхний 4 сарын урьдчилсан гүйцэтгэлээр нийт тэнцэл 202.3 сая ам.долларын ашигтай гарч, өмнөх оны мөн үеэс 522.8 сая ам.доллараар сайжирчээ. Төлбөрийн тэнцэл ийнхүү сайжирсан нь урсгал дансны алдагдал өмнөх оны мөн үеэс 217.6 сая ам.доллараар буурч 86.6 сая ам.долларын ашигтай, хөрөнгө, санхүүгийн дансны тэнцэл мөн үеэс 354.2 сая ам.доллараар сайжирч 279.3 сая ам.долларын ашигтай гарснаар тайлбарлагдаж байна.

Өмнөх оны мөн үед алдагдалтай байсан урсгал тэнцэл 2016 оны эхний 4 сард 86.6 сая ам.долларын ашигтай гарахад төлбөрийн тэнцлийн дэд дансдын ашиг нэмэгдэн, алдагдал буурсан нь голлон нөлөөлжээ. Тодруулбал барааны дансны ашиг 57.5 сая ам.доллараар нэмэгдэж, үйлчилгээний дансны алдагдал 16.6 сая ам.доллараар, цэвэр орлогын дансны алдагдал 101.8 сая ам.доллараар буурсан бол урсгал шилжүүлэг 41.7 сая ам.доллараар нэмэгдсэн эерэг үзүүлэлттэй байна.

Түүнчлэн хөрөнгө, санхүүгийн тэнцэл тайлант хугацаанд 279.3 сая ам.долларын ашигтай гарч 354.2 сая ам.доллараар сайжрахад гадаадын шууд хөрөнгө оруулалт 347.0 сая ам.доллараар, багцын хөрөнгө оруулалт 502.9 сая ам.доллараар, зээл 385.8 сая ам.доллараар өсч, худалдааны зээлийн алдагдал 32.9 сая ам.доллараар буурсан нь эерэгээр нөлөөлсөн бол бэлэн мөнгө, харилцах дансны цэвэр дүн 881.4 сая ам.доллараар буурсан нь сөргөөр нөлөөлжээ.

M2 мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлт 2014 онд 12.5 хувийн өсөлттэй байсан бол 2015 онд 5.5 хувийн бууралттай, 2016 оны эхний 4 сарын байдлаар оны эхнээс 4.7

хувийн өсөлттэй байна. 2015 онд мөнгөний нийлүүлэлт буурахад M1 мөнгө 7.0 хувиар буурсан нь голчлон нөлөөлсөн бол, 2016 оны эхний 4 сард мөнгөний нийлүүлэлт нэмэгдэхэд гадаад валютын харилцах, хадгаламж 443.5 тэрбум төгрөгөөр буюу 15.1 хувиар өссөн нь нөлөөлжээ.

Мөнгөний агрегатууд ийнхүү өсөхөд гадаад активыг нэмэгдүүлэх нөлөөтэй гадаад валютын орох урсгал, түүний дотор ГШХО, багцын хөрөнгө оруулалт, гадаад зээлийн дүн өмнөх оноос нэмэгдсэн нь голчлон нөлөөлөв.

Хүснэгт Т.1

Монгол Улсын макро эдийн засаг, санхүүгийн салбарын голлох үзүүлэлтүүд

	Үзүүлэлт	2015.04	2015	2016.04	
Бодит сектор	Нэрлэсэн ДНБ /тэрбум төгрөг/	4613.7	23166.8	4705.9	***
	Бодит ДНБ-ий өсөлт	4.1%	2.3%	3.1%	***
	Нэрлэсэн ДНБ-ий өсөлт	9.3%	4.2%	2.0%	***
	Инфляци (жилийн)	9.2%	1.9%	2.1%	****
	Ажилгүйдлийн түвшин	7.4%	8.3%	11.6%	****
Төсвийн сектор	Төсвийн тэнцвэржүүлсэн орлого /тэрбум төгрөг/	1675.0	5973.8	1656.3	*
	Төсвийн зарлага /тэрбум төгрөг/	1919.8	7136.9	2319.9	*
	Төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл /тэрбум төгрөг/	-244.8	-1163.2	-663.6	*
	Төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл/ДНБ	-3.1%	-5.0%	-13.1%	***
	Засгийн газрын гадаад өр/сая ам.доллар/	3555.7	3647.9	4035.8	***
	Засгийн газрын гадаад өр/сая ам.доллар/	3555.7	3647.9	4035.8	***
Гадаад сектор	Урсгал тэнцэл (сая ам.доллар)	-131.1	-469.1	86.6	*
	Урсгал тэнцэл (өсөлт)	-82.3%	-66.0%	-166.0%	*
	Хөрөнгө санхүүгийн тэнцэл (сая ам.доллар)	-74.8	380.0	279.3	*
	Хөрөнгө санхүүгийн тэнцэл (өсөлт)	-0.2x	-64.2%	-3.7x	*
	Төлбөрийн тэнцэл (сая ам.доллар)	-320.5	-268.1	202.3	*
	Төлбөрийн тэнцэл (өсөлт)	-23.6%	-43.1%	-0.6x	*
	Гадаадын шууд хөрөнгө оруулалт (сая ам.доллар)	-124.3	110.2	222.7	*
	Гадаадын шууд хөрөнгө оруулалт (өсөлт)	-0.4x	-60.1%	-1.8x	*
	Экспорт (сая ам.доллар)	1452.3	4669.5	1347.4	*
	Экспорт (өсөлт)	1.4%	-19.1%	-7.2%	*
	Импорт (сая ам.доллар)	1034.5	3786.4	862.4	*
	Импорт (өсөлт)	-32.2%	-27.7%	-16.6%	*
	Гадаад худалдааны нийт эргэлт (сая ам.доллар)	2486.7	8455.9	2209.8	*
	Гадаад худалдааны нийт эргэлт (өсөлт)	-15.9%	-23.2%	-11.1%	*
	Гадаад валютын улсын нөөц /сая ам.доллар/	1267.3	1323.2	1544.1	**
	Гадаад валютын улсын нөөц (өсөлт)	-30.4%	-19.8%	21.8%	**
	Ам.долларын ханш (өсөлт)	10.8%	6.0%	1.9%	**
	Нэрлэсэн үйлчилж буй ханш (NEER)-ийн өсөлт	0.1%	1.0%	4.2%	***
	Бодит үйлчилж буй ханш (RER)-ийн өсөлт	5.2%	-0.1%	4.8%	****
	Мөнгө (M2) /тэрбум төгрөг/	9,705.0	10,050.2	10,518.7	**
	Мөнгөний (M2) өсөлт	-4.9%	-5.5%	8.4%	**
Мөнгө, санхүүгийн сектор	Гадаад цэвэр актив /тэрбум төгрөг/	-3284.6	-3908.9	-2648.5	**
	Гадаад цэвэр актив (өсөлт)	-11x	2.3x	-19%	**
	Дотоод цэвэр зээл /тэрбум төгрөг/	14544.1	14890.4	11559.5	**
	Дотоод цэвэр зээл (өсөлт)	22.5%	5.6%	-20.5%	**
	Банкны актив /тэрбум төгрөг/	20498.8	21521.2	22230.8	**
	Банкны актив (өсөлт)	-3.4%	-4.7%	8.4%	**
	Дотоод зээл /тэрбум төгрөг/	12,459	11,902.45	11,869.23	**
	Дотоод зээл (өсөлт)	5.0%	-5.7%	-4.7%	**
	Чанаргүй зээл/нийт зээл	6.1%	7.5%	9.3%	**
	Банк дахь харилцах /тэрбум төгрөг/	2,109	2,208	2,382	**
	Банк дахь харилцах (өсөлт)	-12.8%	-19.9%	12.9%	**
	Банк дахь хадгаламж /тэрбум төгрөг/	7,160	7,340	7,587	**
	Банк дахь хадгаламж (өсөлт)	0.0%	0.1%	6.0%	**
	Банкуудын эзэмшиж буй төвбанкны үнэт цаас /тэрбум төгрөг/	316.31	1,024.77	276.62	**
	Засгийн газрын үнэт цаасны хүү (12 долоо хоногийн хугацаатай)	15.0%	14.9%	13.2%	**
	Бодлогын хүү	13.0%	13.0%	12.0%	**

Эх сурвалж: Монголбанк, Сангийн яам, УСХ.

Тэмдэглэл: *Жил бүрийн эхний 4 сарын гүйцэтгэл

**Жил бүрийн 4 дүгээр сарын эцсийн байдлаар

***Жил бүрийн эхний 3 сарын гүйцэтгэл

****Жил бүрийн эхний 3 сарын эцсийн байдлаарх гүйцэтгэлийн мэдээллийг ашиглан тооцсон үзүүлэлтүүд болно.

Нэгдсэн төсвийн 2016 оны эхний 4 сарын гүйцэтгэлийн мэдээгээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлого 89.1 хувийн гүйцэтгэлтэй буюу 1,656.3 тэрбум төгрөг, зарлага 75.1 хувийн гүйцэтгэлтэй буюу 2,319.9 тэрбум төгрөг, төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 663.6 тэрбум төгрөгийн алдагдалтай гарчээ. Төсвийн зарлагын гүйцэтгэл орлогын гүйцэтгэлтэй харьцуулахад бага байгаа ч төсвийн алдагдал өндөр байгаа нь хувь хүн, аж ахуйн нэгжийн татварын орлого 66.0 тэрбум төгрөгөөр, импортын барааны НӨАТ-ын орлого 40.0 тэрбум төгрөгөөр, татварын бус орлого 241.0 тэрбум төгрөгөөр тасарсан нь голлон нөлөөлж байна. Иймд цаашид төсвийн төлөвлөлт, ялангуяа татварын орлогыг эдийн засгийн суурь үзүүлэлтүүдтэй нийцүүлэн бодитойгоор төлөвлөх шаардлагатайг харуулж байна.

Чингис бондын 500.0 сая ам.долларын эргэн төлөлт 2018 оны 1 дүгээр сард хийгдэх бөгөөд уг бондыг дахин санхүүжүүлэхгүй тохиолдолд 2017 оны улсын төсөвт томоохон дарамт учруулахаар байна. Цаашид нэгдсэн төсвийн тэнцлийг алдагдалгүй болгох нь макро бодлогын хамгийн чухал зорилт болж байна. Учир нь төсөв алдагдалтай байхын хэрээр эдийн засгийн тэнцвэр бүрэн хангагдахгүй бөгөөд макро бодлогын орон зай хязгаарлагдах, улсын гадаад өр нэмэгдэх, хувийн хэвшилд зээл болж очих эх үүсвэр хумигдах, эх үүсвэрийн өртөг нэмэгдэх, хувийн сектор агших зэрэг сөрөг үр дагаврууд үүсэхээр байна.

Банкны салбарт 2016 оны эхний улирлын эцсийн байдлаар нийт 14 банк 1'469 салбар нэгжтэйгээр үйл ажиллагаа явуулж байна. Нийт хадгаламж эзэмшигчдийн тоо 2.4 саяд, зээлдэгчдийн тоо 835.3 мянгад хүрлээ.

Банкны салбарын нийт активын хэмжээ 2016 оны 4 дүгээр сарын байдлаар өмнөх оны мөн үеэс 8.4 хувиар буюу 1732.0 тэрбум төгрөгөөр өсч 22.2 их наяд төгрөг буюу ДНБ-ий 96.0¹ хувьд хүрээд байна. Нийт активын бүтцийг авч үзвэл 52.0 хувь нь зээл, 11.4 хувь нь банкны нөөц, 11.3 хувь нь Засгийн газрын үнэт цаас, 1.2 хувь нь Төв банкны үнэт цаас, үлдэх 24.0 хувь нь бусад хөрөнгө байна.

Монголбанкнаас Засгийн газартай хамтран хэрэгжүүлж байсан хөтөлбөрүүдийн санхүүжилт болон харилцах хадгаламжийн тогтвортой өсөлттэй холбоотойгоор эх үүсвэрийн хэмжээ өсч байсан хэдий ч 2014 оноос хойш өсөлтийн хурд буурч, 2015 онд 6.6 хувийн бууралттай байсан бол 2016 оны эхний 4 сарын байдлаар өмнөх оны мөн үеэс 8.5 хувийн өсөлттэй байна.

Нийт эрэлт буурсантай холбоотойгоор санхүүгийн салбарын зээлийн багцын² 90 гаруй хувийг бүрдүүлж буй банкны зээлийн өсөлт 2015 онд -6.5 хувьд, 2016 оны эхний 4 сарын байдлаар -5.5 хувьд хүрээд байна. Нийт чанаргүй зээлийн хэмжээ 2015 онд 867.3 тэрбум төгрөг, 2016 оны 4 дүгээр сарын байдлаар 1070.4 тэрбум төгрөгт хүрч (нийт зээлийн 9.3 хувь), өмнөх оны мөн үеэс 324.9 тэрбум төгрөгөөр буюу 43.6 хувиар өссөн³ бол хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл 908.5 тэрбум төгрөгт хүрч (нийт зээлийн 7.9 хувь), 647.7 тэрбум төгрөгөөр буюу 48.7 хувиар нэмэгдлээ. Чанаргүй зээлийн өсөлт нь зээлийн эрсдэлийн сангийн зардлыг өсгөснөөр банкны салбарын өөрийн хөрөнгийн болон ашигт ажиллагааны

¹ ДНБ-ий 2015 оны гүйцэтгэлийг ашиглав.

² Арилжааны банк, ББСБ, ХЗХ-ны зээлийн өрийн үлдэгдлийн статистикт үндэслэн тооцов.

³ Татан буугдсан Анод, Зоос, Хадгаламж банкуудыг хасч тооцвол чанаргүй зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 64.4 хувиар өсч 837.4 тэрбум төгрөгт хүрсэн нь нийт зээлийн 7.4 хувьтай тэнцэж байна.

үзүүлэлтэд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна.

2016 оны 1 дүгээр улирлын байдлаар 463 Банк бус санхүүгийн байгууллага, 271 Хадгаламж зээлийн хоршоо, 61 Брокер, дилер, 17 Даатгалын компани, 300 Хувьцаат компани үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд тэдгээрийн тоо жил ирэх тусам нэмэгдэж байна. Гэсэн хэдий ч санхүүгийн салбарт эзлэх хувь бага хэвээр байна.

2016 он гарсаар Монгол Улсын банк, санхүүгийн салбарын эрх зүйн орчныг сайжруулах, санхүүгийн тогтвортой байдлыг хангах чиглэлээр холбогдох хууль тогтоомжид хэд хэдэн өөрчлөлт гарлаа. Тухайлбал Улсын Их Хурал 2016 оны 2 дугаар сарын 5-ны өдөр “Ирээдүйн өв сангийн тухай”, “Ирээдүйн тэтгэврийн нөөц сангийн тухай” хуулиудыг тус тус батлав. Ирээдүйн өв сангийн тухай хууль батлагдсантай холбоотойгоор Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт нэмэлт өөрчлөлт оруулжээ.

Санхүүгийн салбарын үндсэн дэд бүтэц болох төлбөр тооцооны системийн хэвийн үйл ажиллагаа хангагдаж байгаа бөгөөд төлбөр тооцооны системийн нэг өдрийн дундаж үзүүлэлт жил бүр өсөн нэмэгдэж байна.


Санхүүгийн тогтвортой байдлыг үнэлэх “Cobweb” аргачлалын дагуу тооцсон Монгол Улсын санхүүгийн тогтвортой байдлын зураглал, түүний гол үзүүлэлтүүдийн гүйцэтгэлээс харвал:

- ◆ 2012 оноос эхтэй төлбөрийн тэнцлийн хүндрэлтэй нөхцөл байдал 2013 онд хямралын шинжтэй болсны улмаас гадаад секторын эрсдэлийг илэрхийлэх үзүүлэлтийн утга 2014 оны 2 дугаар улиралд дэлхийн санхүү, эдийн засгийн

хямрал нүүрлэсэн 2009 оны үеийн түвшинд буюу 8 нэгжид хүрээд байв. Харин 2011-2013 онд ДНБ-ий -26 хувьтай тэнцэх түвшинд байсан урсгал тэнцэл 2015 оны 2 дугаар хагасаас эхлэн сайжирч, урсгал тэнцлийн алдагдал 2015 онд ДНБ-ий -4 хувь болж буурснаар гадаад валютын улсын нөөц дэх дарамт буурч, улмаар 2015 оны 4 дүгээр улиралд гадаад секторын эрсдэлийг илэрхийлэх үзүүлэлтийн утга 6 нэгж болж өөрчлөгдсөн. Харин 2016 оны эхний улиралд гадаад секторын эрсдэлийг илэрхийлэх үзүүлэлтийн утга өмнөх улирлын түвшинд буюу 6 нэгж гарав.

Дүрслэл Т.1

Монгол Улсын санхүүгийн тогтвортой байдлын зураглал*



Эх сурвалж: Монголбанк, Сангийн яам, УСХ.

Тэмдэглэл: Графикын төвд ойр байх тусам эрсдэл, эмзэг байдал бага, нөхцөл байдал тааламжтай байгааг илтгэнэ.

*Аргачлалтай Монгол Улсын Санхүүгийн тогтвортой байдлын тайлангийн 4 дэх дугаарын 17-р хуудаснаас танилцна уу.

- ◆ Төлбөрийн тэнцлийн хүндрэлт нөхцөл байдал бодит секторт сөргөөр нөлөөлж ДНБ-ий бодит өсөлт саарсны зэрэгцээ төсөвтэй адилтгах зарцуулалтыг оруулж тооцсон төсвийн алдагдлын ДНБ-д эзлэх хувь хэмжээ түүхэн хугацааны дунджаасаа харьцангуй өндөр байснаар макро эдийн засгийн нөхцөл байдлыг илэрхийлэх үзүүлэлтийн утга 2015 онд 7-8 нэгж байв.

Харин 2016 оны эхний улиралд бодит ДНБ-ий өсөлт 3.1 хувь болж өмнөх улирлуудын гүйцэтгэлтэй харьцуулахад бага зэрэг өссөний зэрэгцээ хэрэглээний үнийн индексээр илэрхийлэгдэх инфляцийн түвшин /Улаанбаатар/ 3 сарын эцэст 1.9 хувь болж буурснаар макро эдийн засгийн нөхцөл байдлыг илэрхийлэх үзүүлэлтийн утга 6 нэгж болж буурсан эерэг үзүүлэлттэй байна.

- ◆ 2015 оны 4 дүгээр улиралд 6 нэгж байсан банкны ашигт ажиллагаа, өөрийн хөрөнгийн хүрэлцээ, активын чанарыг илэрхийлэх үзүүлэлтийн утга 2016 оны эхний улиралд 1 нэгжээр өсч 7 нэгж болон мууджээ. Үүнд банкны салбарын чанаргүй зээлийн хэмжээ 2016 оны эхний улиралд өмнөх улирлын эцсээс 11.2 хувиар өсч 964.4 сая төгрөгт хүрсэн нь зээлийн эрсдэлийн сангийн зардлыг нэмэгдүүлэхэд нөлөөлж, улмаар банкны салбар алдагдалтай ажилласан нь голлон нөлөөлөв.
- ◆ Банкны салбарын төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцааг 2012 онд 18 хувиас 25 хувь болгон нэмэгдүүлсэн, банкууд хөрвөх чадвар сайтай эрсдэлгүй санхүүгийн хэрэгсэлд хийх хөрөнгө оруулалтын хэмжээгээ нэмэгдүүлсэнтэй уялдан төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг илэрхийлэх үзүүлэлтийн утга 2012 оны эцсээс тогтвортой сайжирч 2014 оны 1 дүгээр улиралд 4 нэгжид хүрсэн юм. 2015 оны 1 дүгээр улиралд 7 нэгж болж өссөн бөгөөд үүнд нэг талаас банкны салбарын үндсэн эх үүсвэр болох харилцах, хадгаламжийн өсөлт саарсан, нөгөө талаас банкууд харьцангуй өндөр хүүтэй Засгийн газрын дунд болон урт хугацаатай үнэт цаасанд 1.3 их наяд төгрөг буюу нийт активын 6.4 хувийг байршуулсан зэрэг нь нөлөөлсөн. Харин 2016 оны эхний улиралд хөрвөх чадварыг илэрхийлэх үзүүлэлтийн

утга 5 нэгж буюу түүхэн хугацааны дундаж түвшинд байна.

- ◆ Эдийн засгийн идэвхжил саарсан нь өрхийн нэрлэсэн ба бодит орлогыг бууруулж, өрхийн төсөвт хүндрэл учруулж байна. Тухайлбал, өрхийн бодит орлогын жилийн өсөлт 2016 оны эхний улиралд -12 хувь болж буурсны зэрэгцээ өрхийн орлого, зарлагын харьцаа өмнөх улирлаас 10 нэгж хувиар буурч 89 хувь болсон. Ингэснээр өрхийн төсөв санхүүгийн байдлыг илэрхийлэх үзүүлэлтийн утга 2016 оны эхний улиралд өмнөх улирлаас 2 нэгжээр өсч 9 нэгжид хүрч муудсан үзүүлэлттэй байна.

2016 оны эхний улирлын байдлаар иргэдийн чанаргүй зээлийн харьцаа 3.0⁴ хувь буюу төдийлөн өндөр биш байгаа хэдий ч өрхийн төсөв, санхүүгийн хүндрэлт байдал цаашид үргэлжилбэл иргэдийн зээлээ эргэн төлөх чадварт сөргөөр нөлөөлж, улмаар чанаргүй зээлийг улам бүр нэмэгдүүлэн, банкны салбарт бодитоор аюул учруулах эрсдэлтэй байна. Иймд банк, санхүүгийн салбарт эрсдэл хуримтлагдахаас сэргийлэх, болзошгүй эрсдэлийг бууруулах, тогтвортой байдлыг хадгалахын тулд макро эдийн засгийн тэнцвэрийг бүрэн хангаж, улсын төсвийг алдагдалгүй болгон, гадаад валютын орох урсгалыг нэмэгдүүлэх нь чухал хэвээр байна.

⁴ Нийт чанаргүй зээлийн харьцаа 8.2 хувь, хувийн секторын чанаргүй зээлийн харьцаа 12.6 хувь тус тус байна.

МАКРО-САНХҮҮГИЙН ОРЧИН


1.1 ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГ

Хятадын эдийн засгийн идэвх удааширч, газрын тос, металлуудын үнэ буурч, Холбооны Нөөцийн Банк мөнгөний бодлогын төлөвөө чангатгаснаас үүдэн хөгжиж буй орнуудаас хөрөнгө гадагшлах, улмаар эдийн засгийн өсөлт саарахаар байгаа тул ОУВС-ийн шинжээчид дэлхийн эдийн засгийн өсөлтийн төсөөллийг өмнөх төсөөллөөс 0.2 нэгж хувиар бууруулж, 2016 онд 3.2 хувиар өснө гэж үзжээ. Газрын тосны хямд үнэ АНУ, Евро бүсийн дотоод эрэлтийг дэмжих хэдий ч гадаад эрэлт сул байгаа нь экспорт буурах, эдийн засгийн өсөлт нам түвшинд хадгалагдах нэг нөхцөл болж байна.

Дүрслэл 1.1

Дэлхийн эдийн засгийн өсөлтийн төсөөлөл



Эх сурвалж: ОУВС-гийн төсөөлөл, "Дэлхийн эдийн засгийн хандлага (World economic outlook update)" тайлан, 2016 оны 4 дүгээр сар.

2015 онд АНУ-ын эдийн засаг 2.4 хувиар өссөн бол 2016 оны эхний улиралд 1.9 хувиар

өслөө. Хөгжиж буй орнуудын гадаад эрэлт сул, Холбооны Нөөцийн Банк бодлогын хүүгээ нэмж, ам.долларын ханш чангарсан зэргээс шалтгаалан экспорт өмнөх улирлаас 2.6 хувиар буурч, 2015 оны IV улиралд 2.4 хувийн өсөлттэй байсан хэрэглээний зардал дөнгөж 1.9 хувиар өссөн нь эдийн засгийн өсөлт саарахад голлон нөлөөлжээ. АНУ-ын аж үйлдвэрийн салбар дахь нийт үйлдвэрлэл I улиралд өмнөх оны мөн үеэс 1.7 хувиар буурч, PMI индекс сүүлийн 3 сарын турш буурсан зэргээс харахад аж үйлдвэрийн ерөнхий хандлага сайнгүй байна.


Хөдөлмөрийн захын төлөв сайн хэвээр, ажилгүйдлийн түвшин энэ оны эхний улиралд 4.9 хувьд хүрч бууран, 215 мянган ажлын байр шинээр бий болж, ажиллах хүчний оролцооны түвшин 63 хувьд хүрч өсчээ.

Холбооны Нөөцийн Банк 2015 оны 12 дугаар сард бодлогын хүүгээ 0.25 нэгж хувиар нэмсний зэрэгцээ дэлхийн эдийн засаг, санхүүгийн зах зээлийн төлөв, дотоод эдийн засгийн нөхцөлөөс хамааран 2016 онд 2 удаа нэмэгдүүлнэ гэдгээ мэдэгдсэн. 2016 оны 1 дүгээр сард Хятадын хөрөнгийн зах уналтанд орсон, АНУ-ын эдийн засгийн гол үзүүлэлтүүд хүлээлтээс доогуур гарсан зэргээс шалтгаалан Холбооны Нөөцийн Банк 3 болон 6 дугаар сарын хурлаар бодлогын хүүгээ нэмэхээ хойшлуулсан. Харин дэлхийн

санхүүгийн зах зээл тогтворжиж, АНУ-ын ажилгүйдлийн түвшин буурч, инфляци өсч, иргэдийн бодит орлого нэмэгдэж байгаа зэргээс харахад Холбооны Нөөцийн Банк энэ ондоо багтаан бодлогын хүүгээ дахин нэмэх магадлал өндөр байна гэж шинжээчид дүгнэж байна.

Дүрслэл 1.2

АНУ-ын зарим голлох үзүүлэлтүүд



Эх сурвалж: Блүмберг.


Евро бүсийн эдийн засаг 2015 онд 1.8 хувиар өссөн бол 2016 оны эхний улиралд 1.6 хувиар өслөө. Газрын тосны хямд үнэ болон мөнгөний уламжлалт бус тэлэх бодлого дотоод эрэлтийг дэмжиж, 2015 онд дунджаар 1.6 хувийн өсөлттэй байсан хэрэглээний зардал 2016 оны I улиралд 1.5 хувиар өссөн бол экспорт, хөрөнгө оруулалтын өсөлт өмнөх улирлын өсөлтөөс харгалзан 0.5, 1 нэгж хувиар саарсан нь эдийн засгийн өсөлт буурахад хүргэжээ. Евро бүсэд ажилгүйдлийн түвшин буурч, 2016 оны I улиралд 10.4 хувьд хүрчээ. Харин инфляци зорилтот 2 хувиас доогуур байгаа нь эдийн засгийн өсөлт саарах нэг хүчин зүйл болж байна. 2015 онд инфляци дунджаар 0 хувь байсан бол 2016 оны I улиралд мөн 0 хувьд хадгалагджээ.

Эдийн засгийн өсөлтийг дэмжих, инфляцийг зорилтот түвшинд хүргэх зорилгоор Европын Төв Банк бонд худалдан авалтаа 20 тэрбум

еврогоор нэмж, 80 тэрбум еврод хүргэсэн, бодлогын хүүгээ 0.05 хувиас 0 хувьд хүргэж бууруулсан, бизнес эрхлэгчид болон өрхүүдэд олгох зээлийг дэмжих үүднээс урт хугацааны дахин санхүүжилтийн хэрэгслүүдийг нэвтрүүлэх зэргээр QE⁵ хөтөлбөрийн хүрээгээ тэлсэн хэдий ч эдийн засагт үр нөлөө багатай байна. Евро бүсийн дотоод эрэлт нэмэгдэж, Герман, Франц, Итали зэрэг улсын эдийн засгийн ерөнхий дүр зураг сайн байгаа нь бүсийн эдийн засгийг дэмжих хэдий ч Грекийн өрийн хямрал, цагаачдын асуудал, Их Британи Европын Холбооноос гарах (Brexit) зэрэг улс төрийн тодорхой бус байдал хэвээр байгаа нь бүсийн өсөлтөд сөргөөр нөлөөлөхөөр байна.

Дүрслэл 1.3

Евро бүсийн ажилгүйдлийн түвшин



Эх сурвалж: Блүмберг.

2016 оны 1 дүгээр сард Хятадын хөрөнгийн зах уналтанд орж, хөрөнгө гадагшлах урсгал нэмэгдсэн, үйлчилгээний салбарын өсөлт өмнөх улирлын өсөлтөөс 0.6 нэгж хувиар саарсан зэргээс шалтгаалан I улиралд эдийн засгийн өсөлт удааширч, 6.7 хувьд хүрчээ. Харин 2016 оны 3 дугаар сард аж үйлдвэрийн салбар дахь үйлдвэрлэл хүлээлтээс өндөр буюу өмнөх оны мөн үеэс 6.8 хувиар, жижиглэнгийн худалдаа 10.5 хувиар, үл


⁵ Quantitative easing—Эдийн засгийг дэмжих зорилгоор хэрэгжүүлж буй уламжлалт бус мөнгөний тэлэх бодлого юм.

хөдлөх хөрөнгийн салбар дахь хөрөнгө оруулалт 10.7 хувиар тус тус өссөнөөс харахад Хятадын эдийн засаг харьцангуй тогтворжиж, аж үйлдвэрийн салбар аажмаар сэргэж байгааг харуулж байна.

Хятадын эдийн засгийн хувьд тулгамдаж буй асуудлын нэг нь өрийн хурдацтай өсөлт бөгөөд 2016 оны I улирлын байдлаар нийт өр ДНБ-ий 237 хувьтай тэнцэж байна. Хятадын эрх баригчид өрийн асуудал эдийн засгийн өсөлтөнд нөлөө үзүүлэхээргүй гэсэн хэдий ч хувийн секторт эзлэх өр ДНБ-ий 200 гаруй хувийг эзэлж буй нь компаниуд өрийн хямралд өртөх, чанаргүй зээлийн хэмжээ эрс нэмэгдэх, цаашлаад банкны системд тогтворгүй байдал бий болох эрсдэлтэй тул өрийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх шаардлагатайг олон улсын шинжээчид сануулж байна.

Дүрслэл 1.4

БНХАУ-ын нүүрсний импорт (сая тонн)



Эх сурвалж: Блүмберг.

Хятадын аж үйлдвэрийн салбар удааширсан, 2016 оны 1 дүгээр сард хөрөнгийн зах уналтанд орсон, 2015 оны 12 дугаар сард Холбооны Нөөцийн Банк бодлогын хүүгээ нэмж, ам.долларын ханш чангарсан зэргээс шалтгаалан гол түүхий эдүүдийн үнэ 2016 оны 1 дүгээр сард сүүлийн 6 жилийн хамгийн доод түвшинд хүрч буурчээ. Харин Хятадын барилгын салбар идэвхжиж, зэс, төмрийн

хүдэр, коксжих нүүрс зэрэг түүхий эдүүдийг нөөцөлж эхэлснээр эрэлт өсч, үнэ сэргэж байна.


2015 оны IV улиралд нэг тонн нь 89 ам доллар ханштай байсан Австралийн сайн чанарын коксжих нүүрсний жишиг үнэ 2016 оны I улиралд 81 ам долларт хүрч буурсан бол 4 дүгээр сард өсч, 84 ам долларт хүрчээ. Хятадын гангийн үйлдвэрлэл эрчимжиж, коксжих нүүрсний эрэлт нэмэгдсэн, коксжих нүүрсний үйлдвэрлэлээр улсдаа дээгүүрт орох Шанси мужид олборлолт буурснаар импорт 3 дугаар сард өмнөх сараас 72 хувиар өссөн дүнтэй гарсан нь үнэ өсөхөд голлон нөлөөлжээ.

Нэг тонн хүрэн нүүрсний үнэ 2016 оны I улиралд 40 ам долларт хэлбэлзэж байсан бол 4 дүгээр сард 47 ам доллар хүрч өслөө. Уул уурхайн салбарт тэргүүлэх компанийн нэг Би Эйч Пи Билитоны хүрэн нүүрсний үйлдвэрлэл 4 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 24 хувиар буурч нийлүүлэлт саарсан, Хятадын хүрэн нүүрсний импорт 3 дугаар сард 47 хувиар нэмэгдсэн зэргээс шалтгаалан үнэ ийнхүү өсчээ.

Нэг унц алтны үнэ 2016 оны I улиралд 1181 ам доллар байсан бол 4 дүгээр сард 1242 ам долларт хүрч өслөө. Холбооны Нөөцийн Банк бодлогын хүүгээ нэмэхээ удаа дараа хойшлуулж, ам.долларын ханш суларснаас алтны үнэ ийнхүү өсчээ. Алтны импортоор дэлхийд 2-т орох Энэтхэгт энэ оны 2 дугаар сард гоёл чимэглэлийн худалдаанд 1 хувийн татвар ноогдуулах шийдвэр гарснаар алтны эрэлт буурсан нь үнэ өсөхөд мөн нөлөөлжээ.

Дүрслэл 1.5

Бүтээгдэхүүн, түүхий эдийн үнэ



Эх сурвалж: ОУВС.

Тэмдэглэл: *Австралийн ЗГ-ын эрчим хүч, байгалийн нөөцийн тайлан 2016 оны 3 сар, IMF 2 сар, Рубини 4 сарын тайлан дахь төсөөллийн дундаж

**Brent газрын тосны үнийн дундаж


2016 оны I улиралд дунджаар 34 ам.доллар байсан нэг баррель Brent маркийн газрын тосны үнэ 4 дүгээр сард 41 ам.долларт хүрч өсчээ. ОПЕК-ийн гишүүн орон болох Кувейтэд газрын тос олборлогч компаниудын ажилчдын дунд ажил хаялт болж, нийлүүлэлт саарсан нь үнэ өсөхөд голлон нөлөөлсөн. Хямд үнийн нөлөөгөөр Хойд Америк, Кувейт зэрэг орнуудад газрын тосны олборлолт саарах төлөвтэй байгаа бол Иран улс үнийн ямар ч түвшинд нийлүүлэлтээ нэмэх бодлогыг хатуу баримталсаар байна.

ДЭЛХИЙН САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛ

Дэлхийн улс орнууд тэр дундаа бүрэлдэж буй эдийн засагтай орнуудын төлөв байдал сул хэвээр байгаа нь олон улсын санхүүгийн зах зээлд 2016 оны эхээр савалгаа үүсгэлээ. БНХАУ-ын эдийн засгийн өсөлт 2015 онд дөнгөж 6.9 хувь буюу 1990 оноос хойш түүхэн бага түвшинд хүрч, ирэх хоёр жилд ч өсөлт сул байх хандлагатай байгаа нь хөгжиж буй болон хөгжингүй улсуудын эдийн засагт сөргөөр нөлөөлж, олон улсын хөрөнгийн зах зээлд оны эхэнд огцом уналтыг бий болгов.

Дүрслэл 1.6

Зарим хөрөнгийн захын индекс



Тухайлбал, Шанхайн хөрөнгийн биржийн индекс 1 дүгээр сард энэ оны хамгийн доод түвшин буюу 2655.7 нэгжид хүрч оны эхнээс 25 хувиар унасан үзүүлэлттэй байлаа. Хувьцааны үнэ огцом буурсантай холбоотойгоор 2016 оны эхний долоо хоногт БНХАУ шинэ зах зээлийн механизмууд болох алдагдал тодорхой түвшинд хүрсэн үед арилжааг зогсоох арга хэмжээг хоёр ч удаа авсан нь зах зээлд тодорхой бус байдлыг улам нэмэгдүүлсэн явдал болов.

Дүрслэл 1.7

Шанхайн хөрөнгийн биржийн индекс




БНХАУ тэргүүтэй бүрэлдэж буй эдийн засагтай улс орнуудын эдийн засгийн өсөлтийн төлөв сул байгаа нь тэдгээр улсуудын валютын ханшийг сулруулж, түүнчлэн газрын тосны үнэ буурахад нөлөөлжээ. Энэхүү нөхцөл байдал нь хөрөнгө оруулагчдыг эрсдэл багатай хөрөнгө оруулалт хийх сонирхлыг өдөөж, бондын зах зээлд эрэлт нэмэгдэв. Улмаар бондын өгөөжийн муруй хавтгайрч, зээлийн эрсдэлийн үнэ (credit spread) нэмэгдэн зах зээлд тодорхой бус байдал бий болов.

Дэлхийн эдийн засгийн төлөв сайнгүй, төв банкуудын үйл хөдлөл зах зээлд цаашид хүүгийн түвшин буурах хүлээлтийг нэмэгдүүлж, улмаар банкуудын ашигт ажиллагаанд сөргөөр нөлөөллөө. Ялангуяа Япон улс болон Евро бүст банкуудын ашигт ажиллагаа муудаж, хувьцааных нь үнэ ихээхэн унажээ. Энэ нөхцөл байдалд сөрөг арга хэмжээ авахаар 2016 оны 1 дүгээр сарын 29-ний өдөр Японы төв банкны Мөнгөний бодлогын зөвлөлөөс банкуудын заавал байлгах нөөцийн тодорхой хэсэгт сөрөг хүү

тооцох шийдвэрийг гаргав⁶. Гэвч Японы төв банкнаас гаргасан энэхүү шийдвэр нь санхүүгийн захуудад хүчтэй нөлөө үзүүлж, Японы засгийн газрын бондын өгөөж түүхэн доод хэмжээнд буюу сөрөг дүнтэй гарчээ.

Дүрслэл 1.8

Зарим хөгжингүй орнуудын Засгийн газрын 10 жилийн хугацаатай бондын өгөөж



Эх сурвалж: Блүмберг.

Тэмдэглэл: Хамгийн сүүлийн утга нь 2016 оны 6 дугаар сарын 16-ны өдрийн статистик болно.

Төв банкуудын бодлогын арга хэрэгслүүд хязгаартаа тулж, бүтцийн арга хэрэгслүүд богино хугацаанд төдийлөн үр ашиггүй, сангийн бодлогын орон зай хумигдмал байгаа нь дэлхийн эдийн засагт нүүрлээд буй хүндрэлийг даван туулахад бодлогын сонголт улам хязгаарлагдмал болж байгааг харуулж байна.


Хөрөнгө оруулагчид эрсдэлтэй хөрөнгөө арилжаалах болсонтой холбоотойгоор ам.долларын ханш 2016 онд чангарлаа. Олон улсын валютын захад i) АНУ-ын Холбооны Нөөцийн Банкны бодлогын хүүгээ нэмэгдүүлэх хүлээлт, ii) Япон болон Евро бүсийн улсуудын төв банкууд засгийн газрын бонд худалдан авалтаа нэмэгдүүлсэн, бодлогын хүүг бууруулсан, iii) Гол нэрийн

⁶ Бодлогын сөрөг хүүг 2014 оны II улиралд Европын Төв банк, 2014 оны IV улиралд Швейцарын Төв банк тус тус нэвтрүүлээд байсан юм.

түүхий эдийн хэт их нийлүүлэлтээс үүдэлтэй дэлхийн зах зээлд үнийн хэлбэлзэл үүссэн, iv) Их Британи улс Европын холбооноос гарч магадгүй гэсэн хүлээлт үүссэн, v) БНХАУ-ын төв банк мөнгөний зөөлөн бодлого баримталж байгаа зэрэг хүчин зүйлс голлон нөлөөллөө.

Дүрслэл 1.9

Голлох валютуудын ам.доллартай харьцах ханш



Эх сурвалж: Блүмберг.

Тэмдэглэл: Хамгийн сүүлийн утга нь 2016 оны 6 дугаар сарын 16-ны өдрийн статистик болно, 2014.12.31=100.

Холбооны Нөөцийн Банк бодлогын хүүг нэмэгдүүлж магадгүй гэсэн хүлээлт нь хөрөнгө оруулагчдын дунд мөнгөжсөн алтны эрэлтийг нэмэгдүүлж оны эхэнд дэлхийн зах зээлд 1 унц алт 1074.6 ам.доллар байсан бол 2016 оны 6 дугаар сарын 16-ны өдрийн байдлаар 1298.7 ам.долларт хүрч 20.8 хувиар өсчээ.

Дефляцийн эрсдэлээс сэргийлэх зорилгоор Европын төв банкнаас мөнгөний зөөлөн бодлогоо тэлж, засгийн газрын бонд худалдан авах хөтөлбөрөө 4 дүгээр сараас 80 сая евро хүртэл нэмэгдүүлсэн нь еврогийн ханшийг ялимгүй чангарахад нөлөөлөв. Оны эхэнд нэг евро ам.долларын эсрэг 1.08 түвшинд байсан бол 2016 оны 6 дугаар сарын 16-ны өдрийн байдлаар 1.12 түвшинд хүрч 3.9 хувиар чангарчээ.

Их Британи улс Европын холбоог орхиж магадгүй гэсэн хүлээлт Фунт стерлингийн ханшийг ялимгүй сулрахад нөлөөллөө. Оны эхэнд нэг фунт стерлинг ам.долларын эсрэг 1.47 байсан бол 2016 оны 6 дугаар сарын 16-ны өдрийн байдлаар 1.43 түвшинд хүрч 2.9 хувиар сулрав.

Японы төв банкнаас инфляцийг зорилтод түвшин буюу 2 хувьд хадгалах бодлогоо тууштай үргэлжлүүлснээр дотоод захад нийлүүлэх иенийн нийлүүлэлт нэмэгдсэн бөгөөд иенийн ханш ам.долларын эсрэг 2016 оны 6 дугаар сарын 16-ны өдрийн байдлаар 12.7 хувиар чангарав.


БНХАУ-ын эдийн засгийн өсөлт удаашралтай, төв банкны мөнгөний зөөлөн бодлогоос шалтгаалан 2016 оны 6 дугаар сарын 16-ны өдрийн байдлаар юанийн ханш ам.долларын эсрэг 6.59 түвшинд хүрч 1.1 хувиар суларсан байна.

Бүрэлдэж буй эдийн засагтай болон түүхий эд экспортлогч улсуудын валют цаашид ч сулрах хандлагатай байгаа бөгөөд энэ нь дэлхийн зах зээл дэх түүхий эдийн үнээс ихээхэн хамаарч байна. Тухайлбал, зэсийн хувьд дэлхийн нийт хэрэглээний 50 хувийг дангаараа бүрдүүлэгч БНХАУ-ын цэвэршүүлсэн зэсийн импорт 2016 оны 2, 3 дугаар сард өмнөх оны мөн үеэс 50 хувь, 36 хувиар тус тус өсч, томоохон хотуудад орон сууцны эрэлт нэмэгдэж, шинэ орон сууцны үнэ сүүлийн хоёр жилийн хамгийн дээд түвшинд хүрсэн зэргээс шалтгаалан 2016 оны 1 дүгээр сард 4472\$ ам доллар байсан нэг тонн зэсийн үнэ 2 дугаар сараас сэргэж, 4 дүгээр сард 4873\$ ам долларт хүрэв. Хэдийгээр зэсийн үнэ богино хугацаанд өсөлттэй байсан ч энэ нь БНХАУ-ын зэсийн нөөцийг нэмэгдүүлснээс бус зэсийн эцсийн хэрэглээг төдийлөн нэмэгдүүлээгүй хэмээн олон улсын шинжээчид үзэж байна. Зэсийн

үнэ өссөн дээрх хугацаанд Лондонгийн металын бирж дээрх зэсийн нөөц буурсан бол төдий хэмжээгээр Шанхайн агуулахууд дахь зэсийн нөөц нэмэгджээ. Зэсийн үйлдвэрлэл буурч байгаа хэдий ч илүүдэл нийлүүлэлттэй байсаар байгаа нь урт хугацаанд үнэ буурах нөхцөлийг бүрдүүлж байна. Түүнчлэн өмнө нь хийгдсэн хөрөнгө оруулалтын нөлөөгөөр ирэх 2-3 жилд үйлдвэрлэлийн хүчин чадал нэмэгдэхээр байгаа нь зэсийн үнэ цаашид ч буурах нөхцөлийг бүрдүүлж байна.

Дүрслэл 1.10

Зэсийн үнэ ба ам.долларын ханшийн индекс



Эх сурвалж: Блүмберг.

Тэмдэглэл: Хамгийн сүүлийн утга нь 2016 оны 6 дугаар сарын 16-ны өдрийн статистик болно.

Олон улсын банк, санхүүгийн байгууллагуудын төсөөлж байгаагаар одоогийн дэлхийн эдийн засгийн нөхцөл байдал сайжраагүй тохиолдолд дэлхийн зах зээл дээрх 1 тонн зэсийн үнэ 2016 оны эцэст 4400 ам.доллар орчимд, 2017 оны эцэст 4200 ам.долларт хэлбэлзэхээр байна. Харин эдийн засаг сэргэж, зэсийн нийлүүлэлт, баяжмалын агууламж буурах, өндөр үйлдвэрлэлийн зардал бүхий үйлдвэрүүд хаалгаа барих зэрэг тохиолдолд зэсийн үнэ нэмэгдэж магадгүй юм.


1.2 МОНГОЛ УЛСЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

Дэлхийн болон БНХАУ-ын эдийн засгийн өсөлт удааширч байгаагаас шалтгаалан голлох эрдэс бүтээгдэхүүний эрэлт буурч, улмаар үнийн төлөв сайнгүй, АНУ-ын Холбооны Нөөцийн Банк мөнгөний хатуу бодлого баримтлах болсонтой уялдан хөрөнгийн урсгал хөгжиж буй орнуудад бус хөгжингүй орнуудыг чиглэж байгаа нь уул уурхайн олборлолтод суурилсан хөгжиж буй орнуудад томоохон сорилт хэвээр үлдэж байна.

Дүрслэл 1.11

Төлбөрийн тэнцлийн алдагдал




2016 оны эхний 4 сарын урьдчилсан гүйцэтгэлээр төлбөрийн нийт тэнцэл өмнөх оны мөн үеэс 522.8 сая ам.доллараар сайжирч, 202.3 сая ам.долларын ашигтай гарсан бөгөөд энэ нь урсгал дансны бараа, үйлчилгээний алдагдал буурч, хөрөнгө санхүүгийн дансны ашиг нэмэгдсэнээр тайлбарлагдаж байна.

Нэг талаас гадаад, дотоод эдийн засгийн тааламжгүй нөхцөл байдлаас шалтгаалан Монгол Улсад орох гадаадын шууд хөрөнгө оруулалт 2013 оноос хойш огцом буурсаар байгаа ч 2015 онд Оюутолгой төслийн далд уурхайн санхүүжилтийн гэрээг байгуулж, бүтээн байгуулалтын ажил хэвийн үргэлжлэх төлөвтэй байгаа тул дунд хугацаанд манай улсад орж ирэх гадаадын шууд хөрөнгө оруулалт өсөх хүлээлттэй байна. 2015 онд манай улсад үйл ажиллагаа явуулж буй гадны хөрөнгө оруулалттай компаниуд толгой компанидаа зээлээ төлж⁷ хөрөнгө оруулалтын гарах урсгал нэмэгдснээр гадаадын шууд хөрөнгө оруулалт 110.2 сая ам.долларт хүрч байсан бол 2016 оны эхний 4 сард уг үзүүлэлт цэвэр дүнгээр 222.7 сая ам.долларт хүрсэн нь өнгөрсөн бүтэн жилийн үзүүлэлтээс ч 2 дахин өссөн үзүүлэлт юм.

Дүрслэл 1.12

Гадаадын шууд хөрөнгө оруулалт (цэвэр дүнгээр)



⁷ Төлбөрийн тэнцлийн олон улсын стандартын дагуу толгой болон охин компани хоорондын зээллэгийг гадаадын шууд хөрөнгө оруулалт дансанд бүртгэдэг бөгөөд уг зээл төлөгдөх үед тэр хэмжээгээр гадаадын шууд хөрөнгө оруулалтын данснаас хасагдаж, гадаад зээл буурдаг.


Засгийн газар 2015 оны 12 дугаар сард Азийн хөгжлийн банкнаас 100 сая ам.долларын зээл, 2016 оны 3 дугаар сард “Credit Suisse” банкнаас 250 сая ам.долларын зээл авсан бол 4 дүгээр сард олон улсын зах зээлд 500 сая ам.долларын бонд арилжжээ.

2016 оны эхний 4 сарын байдлаар хөрөнгө санхүүгийн данс өмнөх оны мөн үеэс 354.2 сая ам.доллараар нэмэгдэж 279.3 сая ам.долларт хүрчээ.

2008 оноос хойш өндөр алдагдалтай явж ирсэн төлбөрийн тэнцлийн урсгал дансны алдагдал эдийн засаг зөөлөн газардсантай уялдан 2015 онд өмнөх оноос 3 дахин буурч, харин 2016 оны эхний 4 сард өмнөх оны мөн үеэс 166.0 хувиар буурч 86.6 сая ам.долларын ашигтай гарлаа. Урсгал тэнцлийн алдагдал эрс буурсан нь гадаад худалдаа тэнцвэржиж буйтай холбоотой бөгөөд ингэснээр гадаад валютын улсын нөөцөд ирэх дарамт, ачаалал төдий хэмжээгээр буурч байна.

Дүрслэл 1.13

Импортын жилийн өсөлт (жил бүрийн эхний улирлын байдлаар)



Эх сурвалж: Гааль, татварын ерөнхий газар.

Гаалийн статистик мэдээгээр 2014 онд 537.9 сая ам.долларын ашигтай гарч байсан гадаад худалдааны тэнцэл 62 хувиар сайжирч 2015 онд 872.3 сая ам.долларын ашигтай гарав. Гадаад худалдааны ашиг 2016 оны эхний 4

сард өмнөх оны мөн үеэс 16.1 хувийн өсөлттэй буюу 485.0 сая ам.долларт хүрэв.

2016 оны эхний 4 сард өмнөх оны мөн үетэй харьцуулахад хэрэглээний бүтээгдэхүүний импорт 6.1 хувиар, хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн 20.7 хувиар, нефтийн бүтээгдэхүүний импорт 44.4 хувиар буурч, аж үйлдвэрийн орц 5.0 хувиар өсөн, нийт импорт 16.6 хувиар буурсан байна.

Нийт экспорт 2016 оны эхний 4 сарын байдлаар 7.2 хувиар буюу 104.9 сая ам.доллараар буурав. Экспортын бууралтыг ерөнхий бүтээгдэхүүнээр авч үзвэл зэсийн баяжмалын экспорт 4.5 хувиар, чулуун нүүрс 20.1 хувиар буурсан нь голлон нөлөөлжээ. Харин алтны экспорт дээрх хугацаанд 26.0 хувиар өссөн байна.


Хэдийгээр гадаад худалдаа тэнцвэржиж байгаа ч гадаад худалдааны нийт эргэлт өмнөх оны мөн үеэс 11.1 хувиар агшсан нь төсвийн орлого бүрдэлт, цаашлаад эдийн засгийн идэвхжилд сөрөг нөлөө үзүүлж байна.

2014 онд 7.8 хувь, 2015 онд 2.3 хувийн өсөлттэй байсан манай улсын эдийн засаг 2016 оны эхний улиралд 3.1 хувийн өсөлттэй байна. Тайлант улирлын эдийн засгийн өсөлтөд хөдөө аж ахуйн салбар 0.2 хувь, уул уурхай олборлолтын салбар 4.0 хувь, барилга 0.3 хувь, үйлчилгээний салбар 0.2 хувь өссөн нь эерэгээр нөлөөлсөн бол боловсруулах үйлдвэр 0.7 хувь, бөөний болон жижиглэн худалдаа 0.6 хувь, тээвэр агуулахын үйл ажиллагаа 0.2 хувь, бүтээгдэхүүний цэвэр татвар 0.1 хувиар буурсан нь эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөллөө. Өөрөөр хэлбэл 2016 оны эхний улиралд уул уурхай, олборлолтын салбарт голлох өсөлт бий болж бусад салбарт өсөлт сул эсхүл бууралттай хэвээр байна.

Төлбөрийн тэнцлийн хүндрэлээс үүдсэн эдийн засгийн хүндрэл, удаашралын сөрөг нөлөөгөөр худалдааны салбар, нийт импорт агшиж, татварын суурь хумигдаж байгаатай холбоотойгоор бүтээгдэхүүний цэвэр татварын эдийн засгийн өсөлтөд оруулж буй хувь нэмэр улам бүр багасаж, улмаар сүүлийн 9 улирал дараалан сөрөг утгатай гараад байна. Үүнээс үзэхэд улсын төсвийн уул уурхайн салбараас хамаарах хамаарлыг багасгах зайлшгүй тохиргоо шаардлагатай байна.

Дүрслэл 1.14

Улирлын ДНБ-ий жилийн өсөлт, 2010 оны үнээр



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо.
Тэмдэглэл: Урьдчилсан гүйцэтгэл.

2016 оны эхний 4 сарын гүйцэтгэлээр Монгол Улсын нэгдсэн төсөвт 1656 тэрбум төгрөг төвлөрч, орлогын төлөвлөгөө 11 хувиар буюу 202 тэрбум төгрөгөөр тасарлаа.

Хүснэгт 1.1

Төсвийн орлогын тасралт (2016 оны эхний 4 сарын байдлаар, тэрбум төгрөг)

Татварын төрөл	Төлөв.	Гүйц.	Зөрүү	Хувь
Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламж	1 858	1 656	202	89%
Татварын орлого	1 426	1 465	-39	103%
Үүнээс:				
Хувь хүний орлогын албан татвар	175	152	23.0	87%
ААН-ийн орлогын албан татвар	147	104	43.0	71%
Нийгмийн даатгалын орлого	341	491	-149	144%
Дотоодын барааны НӨАТ	160	163	-3	102%
Импортын барааны НӨАТ	213	173	40	81%
Татварын бус орлого	432	191	241	44%
Үүнээс:				
Төсөв байгууллагын өөрийн орлого	129	76	53	59%
Өмч хувьчлалын орлого	24	0	24	1%
Хандив тусламж/гадаал/	140	7	133	5%


Эх сурвалж: Сангийн яам.

Харин төсвийн зарлагын хувьд 75 хувийн гүйцэтгэлтэй буюу 2320 тэрбум төгрөг, төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 664 тэрбум төгрөгийн алдагдалтай гарав.

2015 онд мөнгөний үзүүлэлтүүд бууралттай байсан бол 2016 оны эхний 4 сард өмнөх оны мөн үеэс М2 мөнгөний өсөлт 8.4 хувь, М1 мөнгөний өсөлт 13.7 хувь, банкны зээлийн өсөлт -5.5 хувь, харилцах дансны өсөлт 12.9 хувь, хадгаламжийн өсөлт 6.0 хувь тус тус байна.

Дүрслэл 1.15

Гадаад, дотоод цэвэр актив ба М2 мөнгө



Эх сурвалж: Монголбанк.

Тэмдэглэл: Хамгийн сүүлийн утга нь 2016 оны 3 дугаар сарын статистик болно.


Энэхүү өөрчлөлтөд: (i) төлбөрийн тэнцлийн хүндрэлээс шалтгаалсан гадаад цэвэр активын бууралт, (ii) хөтөлбөрийн зээл хуваарийн дагуу төлөгдөж буйтай холбоотойгоор төв банкнаас банкуудад байршуулсан эх үүсвэр, олгосон зээлийн бууралт, (iii) санхүүгийн зах зээлийн нөхцөл чангарсан, эдийн засгийн идэвхжил удааширснаас банкууд шинээр зээл олгох нь эрсдэлтэй гэж үзэн зээлээ хумьсан, (iv) макро бодлогын нэгдсэн өөрчлөлтөөр эдийн засгийн тэнцвэрийг хангахыг зорьж байгаа зэрэг хүчин зүйлс нөлөөлж байна. Төсвийн алдагдал өсч, мөнгөний нийлүүлэлт хумигдаж буй нөхцөлд эдийн засагт өсч буй эрсдэлийн түвшинг дагаад мөнгөний захын

хүү өсөх бөгөөд энэ нь цаашлаад санхүүгийн систем болон түүний оролцогчдын хөрвөх чадварыг бууруулж, улмаар санхүүгийн болон санхүүгийн бус активуудын үнийг бууруулдаг.

Ийнхүү активын үнэ үргэлжлэн буурах нь санхүүгийн зах зээлд оролцогчдын хувьд төлбөрийн чадварын эрсдэлийг нэмэгдүүлж, санхүүгийн салбарт сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй.

Дүрслэл 1.16

Засгийн газрын үнэт цаасны хүү





Иймд өнөөгийн эдийн засгийн хүндрэлтэй нөхцөл байдалд санхүүгийн тогтвортой байдлыг хадгалах зорилгоор зах зээл дэх хөрвөх чадварыг хадгалах, болзошгүй эрсдэлийг бууруулах нь чухал болоод байна.

Түүнчлэн гадаад валютын тогтвортой орох урсгалыг нэмэгдүүлэх замаар төлбөрийн тэнцлийг ашигтай байлгах арга хэмжээг цаг алдалгүй авч хэрэгжүүлэх шаардлагатай хэвээр байна.

Төлбөрийн тэнцлийг сайжруулахын тулд валютын төлбөртэй экспортыг нэмэгдүүлэх, гадаадын шууд хөрөнгө оруулалт болон багцын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх шаардлагатай.

Дүрслэл 1.17

Төсөв болон мөнгөний бодлогын хүрээнд эдийн засагт хийгдсэн санхүүжилтийн бүтэц ба эдийн засгийн өсөлт



Тэмдэглэл: *ХБ-ны 2015 оны эхний 3 улирлын нийт зарцуулалтаас улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй олгосон зээлийг хасч тооцсон дүн болно. Өмнөх жилүүд төсөв болон мөнгөний бодлогын хүрээнд эдийн засагт нийлүүлэгдсэн нийт санхүүжилт, түүний бодит эдийн засгийн өсөлтийн хамаарлын талаарх дэлгэрэнгүй тайлбартай уг тайлангийн 3 дахь дугаараас танилцана уу (19-20 дахь тал).
**Шинээр олгосон зээл.

Төсөв, мөнгөний бодлого нь эдийн засагт бий болсон сөрөг шокийн нөлөөллийг сулруулж, эдийн засгийг тогтворжуулах, улмаар эдийн засгийн урт хугацааны тогтвортой өсөлтийн суурь нөхцөлийг хангах үндсэн зорилготой. Энэ хүрээнд эдийн засагт шаардлагатай хуримтлал, хамгаалалт (buffer)-ыг бүрдүүлэх нь чухал ач холбогдолтой юм. Тэрхүү хуримтлал, хамгаалалт нь нэг талаас төсвийн тогтворжуулалтын сан, баялгийн сан,

институциональ хөрөнгө оруулалтын сан хэлбэрээр ажиллах, дахин хөрөнгөжүүлсэн нийгмийн даатгалын сан зэрэг тусгай зориулалтын нөөц сангуудын хуримтлал, нөгөө талаас гадаад цэвэр актив, гадаад валютын улсын нөөцийн түвшин зэргээр хэмжигдэнэ.


Эдийн засгийн өрнөлийн үед мөчлөг сөрсөн бодлого хэрэгжүүлж, хуримтлал бий болгосноор уналтын үед харьцангуй бага зардалтайгаар хүндрэлээс гарах нөхцөл бүрдэнэ. Үүний тулд хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, ялангуяа дүрэмд суурилсан, сахилга сайтай төсвийн бодлого хэрэгжүүлэх нь чухал ач холбогдолтой байдаг. Тогтворжуулах зорилгоор хэрэгжүүлж буй богино хугацааны макро эдийн засгийн бодлогоор урт хугацааны эдийн засгийн хөгжлийг зорилт болгох нь хангалттай бус юм. Харин макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах бодлогын зэрэгцээ эдийн засгийн бүтцийг сайжруулахад чиглэсэн урт хугацааны бодлого шаардлагатай юм.

нийлүүлэлтийн гаралтай инфляцийг бууруулсан үнэ тогтворжуулах хөтөлбөрийн эерэг нөлөө, нөгөө талаас нийт эрэлтийг хумьж, мөнгөний бодлогоор макро эдийн засгийн гадаад тэнцвэрийг дэмжсэн болон төлбөрийн тэнцлийн алдагдал 2014-2015 онд буурахын хэрээр валютын зах тогтворжиж, төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн инфляци дахь сөрөг нөлөө саармагжсантай холбоотой.

2016 оны 4 дүгээр сард улсын хэрэглээний үнийн индекс жилийн **2.1** хувиар, Улаанбаатар хотын хэрэглээний үнийн индекс жилийн **1.1** хувиар тус тус өссөн. Дээрх хугацаанд Улаанбаатар хотын жилийн инфляцийг бүтцээр нь задлан авч үзвэл -49 хувийг (-0.9 нэгж хувь) мах, 32 хувийг (0.6 нэгж хувь) махнаас бусад хүнсний бүтээгдэхүүн, 8 хувийг (0.2 нэгж хувь) хувцасны үнийн өсөлт тайлбарласан бол үлдсэн 108 хувийг (2.0 нэгж хувь) бусад бараа, үйлчилгээний үнийн өсөлт бий болгосон байна.

Дүрслэл 1.18

Инфляцийн задаргаа



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк.


Тэмдэглэл: Хамгийн сүүлийн утга нь 2016 оны 4 дүгээр сарын статистик болно.

Инфляцийн түвшин 2014 оны 8 дугаар сараас эхлэн үргэлжлэн буурч байгаа нь нэг талаас

Шигтгээ 1: Монгол Улсын санхүүгийн мөчлөг

Энэхүү тайлангийн өмнөх дугааруудад⁸ санхүүгийн мөчлөг гэж юу болох, манай улсын бизнесийн болон санхүүгийн мөчлөг 2000 оноос хойш хэрхэн явагдаж байгаа талаар дэлгэрэнгүй танилцуулсан билээ.

Өмнөх дугааруудад дурдсан аргачлал, судалгааны аргазүйд үндэслэн Монгол Улсын эдийн засаг, санхүүгийн секторын 2000-2016 оны 1 дүгээр улирал дуусталх тоон мэдээлэлд үндэслэн санхүүгийн мөчлөгийн загварчлалыг шинэчлэв.

Дүрслэл 1.19**Санхүүгийн мөчлөг**

Эх сурвалж: Монголбанк.

Тэмдэглэл: Хамгийн сүүлийн утга нь 2016 оны 1 дүгээр улирлын статистик болно.

Банкны салбарын шинээр олгосон зээл, зээл-ДНБ-ий харьцаа, орон сууцны үнийн индекс, хөрөнгийн зах зээлийн ТОП-20 индекс зэрэг 4 хувьсагчийг сонгон 2000-2016 оны хоорон дахь улирлын давтамжтай тоон мэдээлэлд шинжилгээг хийхэд ТОП-20 индексээс бусад үзүүлэлтүүд хоорондоо маш өндөр хамааралтай байв. Санхүүгийн мөчлөгийн оргил цэгүүд 2003 оны 1, 2007 оны 3, 2013 оны 4 дүгээр улиралд; ёроол цэгүүд 2001 оны 1, 2005 оны 2, 2009 оны 4 дүгээр улиралд тус тус тодорхойлогджээ. 2013 оны 4 дүгээр улирлаас хойш санхүүгийн мөчлөг уналтын төлөвт шилжсэн бөгөөд 2016 оны 1 дүгээр улирлын байдлаар энэ хандлага үргэлжилсээр байна.

⁸ Санхүүгийн мөчлөгийн талаар илүү дэлгэрэнгүйг Санхүүгийн тогтвортой тайлан №3-н 70-р хуудас, №6-н 27-р хуудас.


ГАДААД СЕКТОР

Нийт төлбөрийн тэнцэл

Монгол Улсын төлбөрийн тэнцэл 2016 оны эхний 4 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 202.3 сая ам.долларын ашигтай гарч, өмнөх оны мөн үеэс 522.8 сая ам.доллараар сайжирчээ. Үүнд урсгал тэнцэл 217.6 сая ам.доллараар, хөрөнгө санхүүгийн тэнцэл 354.2 сая ам.доллараар сайжирсан нь голлон нөлөөлсөн байна.

Дүрслэл 1.20

Төлбөрийн тэнцлийн гүйцэтгэл (сая ам.доллар)



Эх сурвалж: Монголбанк.

Тэмдэглэл: *4 дүгээр сарын урьдчилсан гүйцэтгэл.

2016 оны эцэст төлбөрийн нийт тэнцэл алдагдалгүй гарахаар төсөөлөгдөж байна. Энэ нь: (i) Урсгал тэнцлийн алдагдал буурсан, (ii) ГШХО-ын дунд хугацааны төлөв эерэг байх хүлээлттэй байгаа, (iii) багцын болон бусад хөрөнгө оруулалтын орох урсгал нэмэгдсэн зэргээр тайлбарлагдаж байна.


Урсгал данс

Төлбөрийн тэнцлийн урсгал данс 2016 оны эхний 4 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 86.6 сая ам.долларын алдагдалтай гарч, өнгөрсөн оны мөн үеэс 217.6 сая ам.доллараар сайжирлаа. Ийнхүү урсгал тэнцлийн алдагдал буурахад барааны дансны ашиг 11.4 хувиар өсч 560.8 сая ам.долларт, үйлчилгээний

дансны алдагдал 4.6 хувиар буурч 346.9 сая ам.долларт, орлогын дансны алдагдал 34.4 хувиар буурч -193.9 сая ам.долларт, урсгал шилжүүлгийн хэмжээ 167.4 хувиар өсч 66.6 сая ам.долларт тус тус хүрсэн нь нөлөөлжээ.

Дүрслэл 1.21

Урсгал тэнцлийн бүтэц




Эх сурвалж: Монголбанк.

Тэмдэглэл: *4 дүгээр сарын урьдчилсан гүйцэтгэл.

2011-2013 онд дунджаар ДНБ-ий 26.4 хувьтай тэнцэж байсан урсгал тэнцлийн алдагдал 2015 онд ДНБ-ий 4.0 хувь, 2016 оны эхний улиралд ДНБ-ий 0.5 хувь болж буурсан.

Дүрслэл 1.22

Урсгал тэнцлийн санхүүжилт



Эх сурвалж: Монголбанк.

Тэмдэглэл: *4 дүгээр сарын урьдчилсан гүйцэтгэл.

Урсгал дансны алдагдлыг хөрөнгө оруулалтын орох урсгал өндөр байсан 2010-

2012 онд гадаадын шууд хөрөнгө оруулалт, зээлийн эх үүсвэрээр санхүүжүүлж байсан бол 2013-2015 онд гадаад зээл⁹ болон гадаад валютын нөөцийн эх үүсвэрээр голлон санхүүжүүлжээ. Харин 2016 оны эхний 4 сарын урьдчилсан гүйцэтгэлээр урсгал данс ашигтай гарсан нь гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлсэн байна.

Хүснэгт 1.2

Урсгал тэнцлийн алдагдлын санхүүжилт

Огноо	Зээлийн санхүүжилт	Зээлийн бүс санхүүжилт	Гадаад валютын нөөц
2010	20%	179%	-98%
2011	2%	99%	-1%
2012	16%	134%	-51%
2013	23%	18%	58%
2014	41%	26%	34%
2015	9%	34%	57%
2016M4	-282%	148%	234%

Эх сурвалж: Монголбанк.

Хөрөнгө, санхүүгийн данс


Хөрөнгө, санхүүгийн данс 2016 оны эхний 4 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 279.3 сая ам.долларын ашигтай гарсан нь өнгөрсөн оны мөн үеэс 354.2 сая ам.доллараар сайжирсан үзүүлэлт юм.

Ийнхүү хөрөнгө, санхүүгийн дансны тэнцэл сайжрахад гадаадын шууд хөрөнгө оруулалт өнгөрсөн оны мөн үеэс 347.0 сая ам.доллар, багцын хөрөнгө оруулалт 502.9 сая ам.доллар, гадаад зээл 418.6 сая ам.доллараар тус тус нэмэгдсэн нь эерэгээр нөлөөлсөн бол бэлэн мөнгө, харилцах данс 881.3 сая ам.доллараар буурсан нь сөргөөр нөлөөлөв.

⁹ Зээлийн санхүүжилт нь төлбөрийн тэнцлийн тайлангийн бусад хөрөнгө оруулалт хэсгийн худалдааны зээл болон зээлийн дүнгийн нийлбэртэй тэнцүү.

Дүрслэл 1.23

Хөрөнгө, санхүүгийн дансны бүтэц (сая ам.доллар)



Эх сурвалж: Монголбанк.

Тэмдэглэл: * 4 дүгээр сарын урьдчилсан гүйцэтгэл.

Гадаад худалдаа

2016 оны 4 дүгээр сард Монгол Улсын гадаад худалдааны нөхцөлийн индекс (2012 оны 12 сарын суурьтай) 1.321 нэгж болж, өнгөрсөн оноос 19.8 хувиар муудсан үзүүлэлттэй байна.

Дүрслэл 1.24

Гадаад худалдааны нөхцөлийн индекс



Эх сурвалж: Гааль, татварын ерөнхий газар, Монголбанк.


Тэмдэглэл: Хамгийн сүүлийн утга нь 2016 оны 3 дугаар сарын статистик болно.

2016 оны эхний 4 сарын байдлаар экспорт өнгөрсөн оны мөн үеэс 7.3 хувиар буурсан бөгөөд гол нэрийн бүтээгдэхүүний ангиллаар авч үзвэл зэсийн баяжмал 4.5 хувиар (-2.1 нэгж хувь), боловсруулаагүй нефть 19.8

хувиар (-1.7 нэгж хувь), чулуун нүүрс 20.1 хувиар (-2.7 нэгж хувь), төмрийн хүдэр ба баяжмал 44.9 хувиар (-2.5 нэгж хувь) тус тус буурчээ.

Дүрслэл 1.25

Нийт экспорт (жил бүрийн эхний 4 сарын байдлаар)




Эх сурвалж: Гааль, татварын ерөнхий газар.

Импорт өнгөрсөн оны мөн үеэс 16.6 хувиар буурсан бөгөөд гол нэрийн бүтээгдэхүүний ангиллаар авч үзвэл хэрэглээний бүтээгдэхүүн 6.1 хувиар (-1.9 нэгж хувь), хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн 20.7 хувиар (-6.9 нэгж хувь), нефтийн бүтээгдэхүүн 44.4 хувиар (-8.8 нэгж хувь) тус тус буурсан байна.

Дүрслэл 1.26

Нийт импорт (жил бүрийн эхний 4 сарын байдлаар)




Эх сурвалж: Гааль, татварын ерөнхий газар.

Гадаад валютын ханш

Төгрөгийн ам.доллартай харьцах Монголбанкнаас зарласан ханш 2016 оны 4 дүгээр сард 2012.0 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1.8 хувиар суларсан бол гадаад худалдааны эрэлтээр жигнэж тооцсон нэрлэсэн ханш (NEER) 2016 оны 4 дүгээр сарын байдлаар 4.2 хувиар, бодит үйлчилж буй ханш (REER) 4.8 хувиар тус тус суларсан байна. Нэрлэсэн үйлчилж буй ханшийн чангаралт нь дэлхийн зах зээл дээрх ОХУ-ын рублийн ханш ам.долларын эсрэг огцом суларсантай холбоотойгоор дотоодын валютын зах дээрх рублийн эсрэг төгрөгийн ханш сүүлийн жилүүдэд чангарч байгаатай холбоотой юм¹⁰.

Дүрслэл 1.27

Гадаад валютын ханш (жилийн өсөлтийн хувь)



Эх сурвалж: Монголбанк.

Гадаад өр

Монгол Улсын нийт гадаад өр (улсын болон хувийн сектор-ийг нийтэд нь оруулснаар) 2016 оны 1 дүгээр улирлын байдлаар өмнөх оноос 4 хувиар буюу 769.3 сая ам.доллараар нэмэгдэж 22.6 тэрбум ам.долларт хүрлээ. Гадаад өрийн бүтцийн хувьд Төв банкны гадаад өглөг 124.8 сая ам.доллараар, хувийн хэвшлийн гадаад өр 241.0 сая ам.доллараар,

¹⁰ Жигнэсэн дунджаар тооцсон нэрлэсэн болон бодит ханшийг гадаад худалдааны түнш орнуудтай хийсэн худалдааны жингээр жигнэж тооцдог болно.

Засгийн газрын гадаад өр¹¹ 387.9 сая ам.доллараар тус тус өсчээ.

Хүснэгт 1.3

Монгол Улсын нийт гадаад өр (сая ам.доллар)

Үзүүлэлт	2012	2013	2014	2015	2016Q1	Өөрчлөлт	
						Дүн	Хувь
Нийт гадаад өр	15 386	19 022	20 942	21 829	22 599	769	4%
I. Засгийн газар	3 684	3 684	3 610	3 648	4 036	388	11%
II. Товбанк*	415	1 065	1 568	1 960	2 084	125	6%
III. Банк	1 074	1 298	1 629	2 045	2 061	16	1%
Богино хугацаат	58	200	315	331	353	22	7%
Урт хугацаат	1 016	1 098	1 314	1 714	1 707	-6	0%
IV. Бусад сектор	1 856	2 633	3 522	3 501	3 568	67	2%
Богино хугацаат	508	406	562	409	408	-1	0%
Урт хугацаат	1 348	2 228	2 960	3 093	3 161	68	2%
V. Шууд хөрөнгө оруулалт	8 357	10 341	10 615	10 676	10 850	174	2%

Эх сурвалж: Монголбанк.


Тэмдэглэл: *БНХАУ-ын Ардын банкттай хийсэн своп хэлцлийн ашигласан дүнг оруулж тооцдог болно.

Гадаад валютын улсын нөөц

2016 оны 4 дүгээр сарын байдлаар ГВУН өмнөх оны мөн үеэс 21.8 хувиар буюу 276.8 сая ам.доллараар өсч 1544.1 сая ам.долларт хүрэв. Гадаад валютын улсын нөөцөөр импортын хэрэгцээг хангах түвшин¹² 7.7 сард хүрч өмнөх оны үзүүлэлтээс 2.5 сараар сайжирлаа.

Дүрслэл 1.28

Гадаад валютын улсын нөөц



Эх сурвалж: Монголбанк.

Тэмдэглэл: Хамгийн сүүлийн утга нь 2016 оны 4 дүгээр сарын статистик болно.


Монгол Улсын зээлжих зэрэглэл

Олон улсын зэрэглэл тогтоогч Фитч, Стандарт энд пүүрс, Мүүдиз агентлагуудаас тогтоож буй Монгол Улсын зээлжих зэрэглэлийн өөрчлөлтөөс үзэхэд сүүлийн жилүүдэд манай улсын зээлжих зэрэглэл¹³ болон төлөв¹⁴ буурснаар хөрөнгө оруулалтын хувьд өндөр эрсдэлтэй орны ангилалд орох болсон.

Стандарт энд пүүрс агентлаг хамгийн сүүлд буюу 2016 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр Монгол Улсын зээлжих зэрэглэлийн шинчилсэн үнэлгээг хийж зэрэглэл болон төлөвийг “В-тогтвортой” хэвээр үнэллээ.

Дүрслэл 1.29

Олон улсын зах зээлд гаргасан Монгол Улсын Засгийн газрын бондын үнэ (ам.доллар)



Эх сурвалж: Блүмберг.

Тэмдэглэл: *Хамгийн сүүлийн утга нь 2016 оны 6 дугаар сарын 16-ны өдрийн статистик болно. Бондын үнэ болон өгөөж (хүү) нь урвуу хамааралтай бөгөөд үнэ өсөх нь тухайн бондын эрсдэл буурч байгааг илтгэнэ.

Тус агентлаг Монгол Улсын эдийн засгийн өсөлтийн төлөв сул хэвээр, экспортын гол нэрийн бүтээгдэхүүнүүдийн дэлхийн зах зээл дээрх үнэ өсөх хандлагагүй байгаа тул

¹³ Тухайн улсын Засгийн газрын зээлийн чадварыг илэрхийлдэг ба худалдааны нөхцөлтэй авсан өр төлбөрөө хугацаанд нь, бүтнээр эргэн төлөх чадвартай эсэх мөн тус үүргээ биелүүлэх бэлэн байдлыг харуулдаг.

¹⁴ Зээлжих зэрэглэлийн хандлагыг илтгэх бөгөөд “эерэг” төлөв нь зэрэглэл дээшлэх боломжийг, “сөрөг” төлөв нь зэрэглэл буурч болох эрсдэл байгааг илэрхийлнэ.

¹¹ Засгийн газрын баталгаа бүхий гадаад зээлийг оруулаагүй.

¹² ГВУН-ийг валютын төлбөртэй импортын сүүлийн 3 сарын дундаж үзүүлэлтэд харьцуулж тооцсон.

экспортын орлого нэмэгдэх төлөвгүй, гадаадын шууд хөрөнгө оруулалтын урсгал бага хэвээр байгаа нь улсын төсөв, төлбөрийн тэнцэлд дарамт учруулж байна гэж үзжээ. Түүнчлэн Засгийн газрын өр нэмэгдсэн нь улсын төсөвт эрсдэл учруулж буйг онцлон, банкны салбарт мөн эрсдэл нэмэгдэж байгаа талаар тайландаа дурджээ. Дараагийн үнэлгээг 2016 оны 9-10 дугаар сард гүйцэтгэх төлөвлөгөөтэй байна. Харин төлөвийг тогтвортой болгон сайжруулахад томоохон уул уурхайн төслүүдийг эхлүүлснээр Монгол Улсын зээлжих зэрэглэл ирэх 12 сарын хугацаанд сайжрах боломжтой гэж үзжээ.

Хүснэгт 1.4

Монгол Улсын зээлжих зэрэглэлийн өөрчлөлт

Огноо	Moody's			Fitch			Standard and Poors'		
	Үнэлгээ	Төлөв		Үнэлгээ	Төлөв		Үнэлгээ	Төлөв	
2005	VII/18			B+	**	—			
	X/4	B1	**	—			B	**	—
	XI/1						B	*	↗
	XII/29								
2006	XII/26						B+	▲	*
2007	XII/13			B+	*	↗	BB-	▲	**
	IX/20								—
2008	VI/2			B+	**	—			
	XII/9			B+	***	↘			
	XII/19						BB-	***	↘
2009	I/18			B	▼	***	↘		
	VI/10	B1	***	↘					
	X/30	B1	**	—					
	X/11			B	**	—			
	XI/20						BB-	**	—
2010	XI/23			B+	▲	**	—		
2011	XII/19						BB-	*	↗
2012	X/29						BB-	**	—
2013	IV/16						BB-	***	↘
	XII/13			B+	***	↘			
2014	IV/29						B+	▼	**
	V/26	B1	***	↘					
	VII/17	B2	▼	***	—				
	XII/11			B+	***	—			
2015	IV/29						B+	***	↘
	XI/03						B	**	—
	XI/04			B	▼	**			
	XI/24			B	**				
2016	I/14	B2	***	B	**		B	**	
	III/31	B2	***						
	IV/28						B	**	

Зэрэглэлийн өөрчлөлт ▲, ▼; төлвийн өөрчлөлт ↗, ↘

*-эерэг, **-тогтвортой, ***-сөрөг

Эх сурвалж: Moody's, Fitch, S&P's, Монголбанк.

БОДИТ СЕКТОР

Манай улсын эдийн засгийн өсөлт 2016 оны эхний улирлын байдлаар 3.1 хувьтай гарлаа.

2012 оны 1 дүгээр улирлаас эхлэн тасралтгүй саарсан эдийн засгийн өсөлт 2013 оны 1 дүгээр улиралд 7.1 хувьд хүрч, мөчлөг сөрсөн макро бодлогын нөлөөгөөр 2 дугаар улирлаас нэмэгдэж, улмаар 2013 онд ДНБ-ий бодит өсөлт 11.7 хувь гарсан. Үүнд хөдөө аж ахуй, уул уурхай болон барилгын салбарын өсөлт ихээхэн нөлөөлсөн юм.

Хүснэгт 1.5

Бодит салбарын үндсэн үзүүлэлтүүд, 2010 оны зэрэгцүүлэх үнээр

	2015					2016*
	I	II	III	IV	I-IV	I
Бодит ДНБ, тэрбум төгрөг	2 850	4 217	4 471	4 300	15 838	2 938
Уул уурхайн	705	827	1 135	1 253	3 919	819
Уул уурхайн бус	1 839	2 884	2 977	2 814	11 919	1 817
Бодит ДНБ-ий өсөлт	4.1%	2.3%	0.8%	2.7%	2.3%	3.1%
Уул уурхайн	13.4%	18.1%	8.3%	13.9%	13.0%	16.2%
Уул уурхайн бус	4.6%	1.9%	1.5%	3.9%	-0.8%	-1.2%


Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо.

Тэмдэглэл: *Урьдчилсан гүйцэтгэл.

2014 оноос эхтэй төлбөрийн тэнцлийн хүндрэл, гадаадын шууд хөрөнгө оруулалтын орох урсгал үлэмж буурснаас шалтгаалж дотоод эрэлт хумигдан эдийн засгийн өсөлт 7.9 хувь хүртэл буурч, энэхүү буурах хандлага 2015 онд хадгалагдсанаар ДНБ-ий бодит өсөлт 2.3 хувьд хүрчээ.

Дүрслэл 1.30

Эдийн засгийн өсөлтийн задаргаа



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо.

Харин 2016 оны эхний улиралд ДНБ-ий өсөлт харьцангуй сайжирч 3.1 хувьд хүрэв. Үүнд уул уурхайн салбар 16.2 хувиар өссөн нь голчлон нөлөөлсөн бөгөөд уул уурхайн бус салбарууд 1.2 хувийн бууралттай байна. Өсөлтөд үзүүлсэн нөлөөллийг авч үзвэл нийт 3.1 хувийн өсөлтийн 4.0 нэгж хувийг уул уурхайн салбар дангаараа бүрдүүлжээ. 2016 оны эхний улиралд уул уурхайгаас гадна хөдөө аж ахуй, барилга, үйлчилгээ зэрэг салбарууд өсөлттэй буюу эдийн засгийн өсөлтийг 0.8 нэгж хувиар өсгөх нөлөөг үзүүлсэн бол боловсруулах үйлдвэрлэл, худалдаа, тээвэр, агуулахын үйл ажиллагаа, бүтээгдэхүүний цэвэр татвар буурсан үзүүлэлттэйгээр эдийн засгийн өсөлтийг 1.7 нэгж хувиар сааруулах нөлөөг үзүүлсэн байна.

Хүснэгт 1.6

ДНБ-ий бодит өсөлт (салбаруудаар)

Бодит ДНБ	2015		2016Q1	
	2.3%	100%	3.1%	100%
1 Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	1.3%	56.1%	0.2%	5.0%
2 Уул уурхай, олборлолт	2.9%	126.5%	4.0%	130.5%
3 Боловсруулах үйлдвэрлэл	0.1%	3.3%	-0.7%	-23.9%
4 Цахилгаан, хий, уур, агааржуулалт	0.0%	2.1%	0.1%	4.0%
5 Барилга	-0.1%	-2.3%	0.3%	9.4%
6 Бөөн/жиж худалдаа; машин, мотоцикл засвар үйлчилгээ	-0.5%	-22.3%	-0.6%	-19.6%
7 Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	0.4%	15.3%	-0.2%	-6.4%
8 Мэдээлэл, холбоо	0.0%	2.2%	0.0%	0.5%
9 Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	0.6%	25.0%	0.2%	5.4%
10 Бүтээгдэхүүний цэвэр татвар	-2.4%	-106.0%	-0.1%	-4.9%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо.


Банкуудын зээлийн өрийн үлдэгдэлд өндөр жин эзэлдэг худалдаа, барилгын салбаруудын өсөлт сөрөг гарч, боловсруулах салбарын өсөлт ихээр саарсан нь зээлийн чанарыг муутгаж, улмаар банкны системийн үйл ажиллагаанд хүндрэл учруулж болзошгүй юм.

МӨНГӨ САНХҮҮГИЙН СЕКТОР

M2 мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлт 2014 оны 2 дугаар улирлаас эхлэн саарсаар 2015 оны эцэст -5.5 хувьд хүрсэн бол 2016 оны 4 дүгээр сарын байдлаар жилийн 8.4 хувийн өсөлттэй байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад M1 мөнгөний өсөлт 13.7 хувь, банкны зээлийн өсөлт -5.5 хувь, харилцах дансны өсөлт 12.9 хувь, хадгаламжийн өсөлт 6.0 хувь тус тус байна.

Дүрслэл 1.31

M2 мөнгөний бүтэц (жилийн өсөлтийн хувь)



Эх сурвалж: Монголбанк.

Тэмдэглэл: Хамгийн сүүлийн утга нь 2016 оны 4 дүгээр сарын статистик болно.


2016 оны 4 дүгээр сард банкнаас гадуурх мөнгө өмнөх оны мөн үеэс 115.3 тэрбум төгрөгөөр, төгрөгийн харилцах 87.2 тэрбум төгрөгөөр тус тус өссөн нь M1 мөнгөний жилийн өсөлтийн 7.8 ба 5.9 нэгж хувийг тус тус тайлбарлаж байна. Харин бусад хадгаламж жилийн 7.4 хувийн өсөлттэй байгаагийн 1.0 нэгж хувийг валютын хадгаламж, 4.2 нэгж хувийг төгрөгийн хадгаламж, 2.3 нэгж хувийг валютын харилцах тус тус бүрдүүлэв.

Мөнгөний үзүүлэлтүүдийн өсөлт 2009 оны эцсээс тасралтгүй өссөөр 2011 оны 2 дугаар улиралд оргилдоо хүрч, түүнээс хойш төлбөрийн тэнцлийн хүндрэлээс шалтгаалсан гадаад активын бууралтаас хамааран саарч эхэлсэн. Монголбанкнаас 2012 оны 4 дүгээр

улирлаас эхлэн хэрэгжүүлсэн эдийн засгийг тогтворжуулж, зөөлөн газардуулах арга хэмжээний нөлөөгөөр мөнгөний үзүүлэлтүүдийн өсөлт тогтворжиж, улмаар сэргэж байсан хэдий ч, гадаад цэвэр активын бууралт, макро эдийн засгийн гадаад тэнцвэрийг дэмжих бодлогын арга хэмжээний нөлөөгөөр мөнгөний үзүүлэлтүүд 2014 оны 1 дүгээр улирлаас эхлэн буурч, энэ хандлага 2015 оныг дуустал үргэлжилсэн.

Дүрслэл 1.32

M2 мөнгөний жилийн өсөлтийн задаргаа



Эх сурвалж: Монголбанк.


Тэмдэглэл: Хамгийн сүүлийн утга нь 2016 оны 1 дүгээр улирлын статистик болно.

M2 мөнгийг байршуулалт талаас нь харвал 2016 оны 4 дүгээр сарын байдлаар дотоод цэвэр зээл жилийн -20.5 хувийн бууралттай байна. Үүний -8.6 нэгж хувийг Засгийн газрын зээл, -8.4 нэгж хувийг бусад санхүүгийн байгууллагуудын зээл, -0.5 нэгж хувийг хувийн байгууллагуудын зээлийн бууралт тус тус бүрдүүлж байна.

Төлбөрийн тэнцлийн хүндрэлээс шалтгаалан Монгол Улсын гадаад цэвэр актив (ГЦА) 2013 оноос хойш буурсаар 2016 оны 1 дүгээр улиралд -4086.0 тэрбум төгрөг хүрээд байсан бол 4 дүгээр сард -2648.5 тэрбум төгрөгт хүрлээ. Энэ нь өмнөх оны мөн үеэс 19.4 хувиар өссөн үзүүлэлт юм.

Дүрслэл 1.33

Мөнгөний үзүүлэлтүүдийн ерөнхий бүтэц ба хандлага (тэрбум төгрөг)




Эх сурвалж: Монголбанк.

Гадаад валютын харилцах, хадгаламжийн M2 мөнгөнд эзлэх хувь харьцангуй тогтвортой байгаа бөгөөд 2016 оны 4 дүгээр сарын байдлаар 32.1 хувьтай байна.

Дүрслэл 1.34

Мөнгөний нийлүүлэлт ба мөнгөний үржүүлэгч



Эх сурвалж: Монголбанк.


Мөнгөний үржүүлэгч¹⁵ 2011 оны 2 дугаар сард 5.7 нэгж болж 2000 оноос хойшхи хамгийн өндөр түвшиндээ хүрч байсан бол 2016 оны 4 дүгээр сарын байдлаар 3.5 нэгж байна.

¹⁵ Нөөц мөнгөний нэгж өсөлт нь хэдий хэмжээний нийт мөнгө (M2)-ний өсөлт бий болгосныг харуулах бөгөөд M2 мөнгө ба нөөц мөнгөний харьцаагаар тодорхойлогдоно.

Эдийн засагт орж ирэх гадаад валютын урсгал сэргээгүй, гадаадын шууд хөрөнгө оруулалт буурсаар байсан нөхцөлд нийт эрэлт, урсгал тэнцлийн алдагдлыг бууруулах, эдийн засгийн гадаад тэнцвэрийг дэмжих, инфляцийг нам, тогтвортой түвшинд байлгах, санхүүгийн болон макро эдийн засгийн тогтвортой байдлыг дэмжих зорилгоор Монголбанкны мөнгөний бодлогын зөвлөл 2015 оны 1 дүгээр сарын хуралдаанаараа мөнгөний бодлогын хүүг 1.0 нэгж хувиар нэмэгдүүлэн, 13.0 хувь болгох, 2015 оны 4 ба 7 дугаар сард энэ түвшинд хэвээр хадгалах шийдвэр тус тус гаргасан юм. Харин инфляцийн түвшин сүүлийн 9 сарын турш нам, тогтвортой түвшинд байж, цаашид энэ хандлага хадгалагдахаар байгаа гадаадын шууд хөрөнгө оруулалтын дунд хугацааны төлөв эерэг байхын зэрэгцээ, 2016 оны төлбөрийн тэнцэл алдагдалгүй байх төсөөлөлтэй байгаа нь мөнгөний бодлогыг зөөлрүүлэх орон зайг нэмэгдүүлж 2016 оны 1 дүгээр сард мөнгөний бодлогын хүүг 1 нэгж хувиар бууруулж 12 хувь, 5 дугаар сард 1.5 нэгж хувиар дахин бууруулж 10.5 хувь болголоо.

Дүрслэл 1.35

Банкуудын хадгаламж болон зээлийн хүү



Эх сурвалж: Монголбанк.


Тэмдэглэл: *Ипотекийн зээлийн хүүг оруулж тооцсон.

Санхүүжилтийн нөхцөл чангарсантай холбоотойгоор банкуудын төгрөгийн зээлийн

жигнэсэн дундаж хүү¹⁶ 2015 оны 12 дугаар сард 18.3 хувьд хүрээд байсан бол 4 дүгээр сард бага зэрэг буурч жилийн 17.5 хувьд хүрэв. Хадгаламжийн жигнэсэн дундаж хүү өмнөх оны мөн үеэс 4.1 нэгж хувиар өсч жилийн 13.4 хувьд хүрснээр хүүний зөрүү 4.1 нэгж хувь байна.

Дүрслэл 1.36

Банк хоорондын захын хүү




Эх сурвалж: Монголбанк.

Тэмдэглэл: Хамгийн сүүлийн утга нь 2016 оны 4 дүгээр сарын статистик болно.

“Хүүний коридор” нэвтрүүлснээс хойш буюу 2013 оны 2 сараас хойшхи хугацаанд богино хугацаат хэлцлийн хүүнүүд бодлогын хүүнээс +/-2 хувийн дотор хэлбэлзэж байна.

Дүрслэл 1.37

Банк хоорондын захын хүүний хэлбэлзэх интервал**



Эх сурвалж: Монголбанк.

Тэмдэглэл: *2016 оны эхний 4 сарын байдлаар.

**Банк хоорондын захын хүүний жил бүр хэлбэлзэх интервалыг тухайн жилийн хамгийн их утгаас хамгийн бага утгыг хасч тооцов.

Тухайлбал, 2016 оны 4 дүгээр сарын байдлаар бодлогын хүү 12 хувь, овернайт хүү 12.9 хувь, репо хүү 12.7 хувь байна.

¹⁶ Банкуудын зээлийн жигнэсэн дундаж хүү нь Монголбанкны хөтөлбөрийн (ҮТХ) зээлийг оруулан тооцсон хүү болно. Харин хөтөлбөрийн зээлийг хасч тооцвол төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү 2016 оны 3-р сарын байдлаар 19.7 хувь байна.

УЛСЫН ТӨСӨВ

Нэгдсэн төсвийн орлогын урьдчилсан гүйцэтгэл

2016 оны 4 дүгээр сарын нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн мэдээгээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлого 89.1 хувийн гүйцэтгэлтэй буюу 1656.3 тэрбум төгрөг, зарлага 75.1 хувийн гүйцэтгэлтэй буюу 2319.9 тэрбум төгрөг, төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 663.6 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа.

Хүснэгт 1.7

Нэгдсэн төсвийн орлогын төлөвлөгөө ба гүйцэтгэл (тэрбум төгрөг)

Нэгдсэн төсвийн орлого	Жилийн төлөвлөгөө	2016 оны эхний 4 сар		
		*	**	**/*
Нийт орлого ба тусламжийн дүн	7 071	1 860	1 656	89%
Тогтворжуулалтын сан	9	2	0	0%
Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн	7 063	1 858	1 656	89%
I. Татварын орлого	5 588	1 426	1 466	103%
1. Орлогын албан татвар	1 102	292	239	82%
1.1. Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	560	147	104	70%
1.2. Хүн амын орлогын албан татвар	592	175	152	87%
2. Нийгмийн даатгалын шимтгэл, хураамж	1 173	342	491	144%
3. Хөрөнгийн албан татвар	90	29	34	116%
4. Нэмэгдсэн өртгийн албан татвар	1 442	335	314	94%
5. Онцгой албан татвар	710	182	164	90%
6. Тусгай зориулалтын орлого	11	2	3	138%
7. Гадаад үйл ажиллагааны орлого	404	96	78	82%
8. Бусад татвар, төлбөр, хураамж	656	149	143	96%
II. Татварын бус орлого	1 475	432	191	44%
1. Нийтлэг татварын бус орлого	934	268	184	69%
2. Хөрөнгийн орлого	172	24	0	1%
3. Тусламжийн орлого	368	140	7	5%

Эх сурвалж: Сангийн яам.

Тэмдэглэл: *Төлөвлөгөө,

**Урьдчилсан гүйцэтгэл.

Нэгдсэн төсвийн орлогын тасралтад татварын орлогын бүрэлдэхүүнд багтах ААН-ийн орлогын албан татвар 43.4 тэрбум төгрөг, хувь хүний орлогын албан татвар 22.5 тэрбум төгрөг, импортын барааны НӨАТ 40.2 тэрбум төгрөг, импортын гаалийн албан татвар 17.8 тэрбум төгрөг, татварын бус орлогын бүрэлдэхүүнд багтах төсвийн байгууллагын өөрийн орлого 53.3 тэрбум төгрөг, газрын тосны орлого 19.4 тэрбум төгрөг, өмч хувьчлалын орлого 23.8 тэрбум төгрөг, гадаад хандив тусламжийн орлого 133.1 тэрбум төгрөгөөр тус тус тасарсан нь голлон нөлөөлжээ. Харин нийгмийн даатгалын

орлогын гүйцэтгэл төлөвлөсөн дүнгээс 149.3 тэрбум төгрөгөөр давж биелсэн байна.

Хүснэгт 1.8

2016 оны эхний 4 сарын нэгдсэн төсвийн орлогын гүйцэтгэл, үндсэн бүрэлдэхүүнээр (тэрбум төгрөг)

Төсвийн орлого	УТ*	ОНТ*	ХХС*	НДС*
Нийт орлого ба тусламжийн дүн	943	690	43	680
Тогтворжуулалтын сан	0	0	0	0
Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн	943	690	43	680
I. Татварын орлого	714	218	43	542
1. Орлогын албан татвар	104	135	0	0
1.1. Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	104	0	0	0
1.2. Хүн амын орлогын албан татвар	0	152	0	0
1.3. Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн татвар	0	0	0	0
2. Нийгмийн даатгалын шимтгэл хураамж	0	0	0	542
3. Хөрөнгийн албан татвар	0	34	0	0
4. Нэмэгдсэн өртгийн албан татвар	314	0	0	0
5. Онцгой албан татвар	164	0	0	0
6. Тусгай үйл ажиллагааны орлого	3	0	0	0
5. Гадаад худалдааны орлого	78	0	0	0
6. Бусад татвар	51	49	43	0
II. Татварын бус орлого	229	472	0	139

Эх сурвалж: Сангийн яам.

Тэмдэглэл: *УТ- Улсын төсөв, ОНТ- Орон нутгийн төсөв, ХХС- Хүний хөгжил сан, НДС- Нийгмийн даатгалын сан.

Хүний хөгжил сангийн орлого

Хүний хөгжил сан нь 2009 онд байгуулагдсан бөгөөд тус санд 2010-2015 хугацаанд нийт дүнгээр 2161.4 тэрбум төгрөг төвлөрүүлсэн хэдий ч, сангийн орлогыг хуримтлуулахгүй бүхэлд нь иргэдэд хишиг, хувь хэлбэрээр тарааж ирсэн. 2016 оны эхний 4 сарын байдлаар 42.5 тэрбум төгрөгийн орлого төвлөрсөн нь төлөвлөгөөнөөс 11.0 хувиар буюу 5.3 тэрбум төгрөгөөр дутуу төвлөрсөн байна. Энэ нь ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлого дутуу биелсэнтэй холбоотой юм.

Нийгмийн даатгалын сангийн орлого

Нийгмийн даатгалын санд 680.4 тэрбум төгрөг төвлөрсөн нь төлөвлөгөөнөөс 27.5 хувиар буюу 146.6 тэрбум төгрөгөөр илүү биелэлттэй байна. Тус санд 2016 оны эхний 4 сард улсын төсвөөс 138.6 тэрбум төгрөгийн татаас олгоод байна.

Төсвийн зарлагын гүйцэтгэл

Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт зарлага 2016 оны эхний 4 сарын байдлаар 3089.0 тэрбум төгрөгөөр төлөвлөгдсөнөөс 2319.9 тэрбум төгрөг буюу 75.1 хувийн гүйцэтгэлтэй гарлаа.

Хүснэгт 1.9

Нэгдсэн төсвийн зарлагын төлөвлөгөө ба гүйцэтгэл (тэрбум төгрөг)

Нэгдсэн төсвийн зарлага	Жилийн төлөвлөгөө	2016 оны эхний 4 сар		
		*	**	***
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	8 003	3 089	2 320	75%
Урсгал зардал	6 271	2 362	1 968	83%
1. Бараа, үйлчилгээний зардал	2 963	1 142	928	81%
1.1. Цалин хөлс	1 709	580	559	96%
1.2. Нийгмийн даатгал	157	54	51	95%
1.3. Бараа, үйлчилгээний бусад зардал	1 097	508	318	63%
2. Зээлийн үйлчилгээний төлбөр	933	264	206	78%
3. Татаас	212	94	69	73%
4. Урсгал шилжүүлэг	2 164	861	765	89%
Хөрөнгийн зардал	1 931	682	329	48%
1. Дотоод эх үүсвэрээр:	1 517	535	202	38%
Эргэж төлөгдөх цэвэр зээл	-199	45	23	51%
Тэнцвэржүүлсэн нийт тэнцэл	-941	-1 231	-664	54%

Эх сурвалж: Сангийн яам.

Тэмдэглэл: *Төлөвлөгөө,

**Урьдчилсан гүйцэтгэл.

Үүнээс урсгал зардал 393.1 тэрбум төгрөг, хөрөнгийн зардал 353.7 тэрбум төгрөгөөр тус тус дутуу гүйцэтгэлтэй гарчээ. Урсгал зардлын бүрэлдэхүүнд багтах цалин хөлс 20.9 тэрбум төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 73.0 тэрбум төгрөг, бараа, үйлчилгээний бусад зардал 73.2 тэрбум төгрөг, дотоод зээлийн үйлчилгээний төлбөр 56.0 тэрбум төгрөг, төрөөс иргэдэд олгох тэтгэмж 26.6 тэрбум, хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас 23.9 тэрбум төгрөг, хөрөнгийн зардлын бүрэлдэхүүнд багтах дотоод эх үүсвэрээрх хөрөнгө оруулалт 333.7 тэрбум төгрөгөөр тус тус дутуу биелэлттэй байлаа.

Хүний хөгжил сангийн зарлага

2016 оны эхний 4 сарын байдлаар Хүний хөгжил сангийн зарлага 131.9 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөгдсөн нийт зардал 94.9 хувийн гүйцэтгэлтэй байна. Тус сангаас хүүхдэд


олгож байгаа бэлэн мөнгөний санхүүжилтээр 101.6 тэрбум төгрөгийг олгожээ.

Нийгмийн даатгалын сангийн зарлага

Нийгмийн даатгалын сангийн төлөвлөгдсөн зардал 93.8 хувийн буюу 535.7 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Тус сангаас улсын эмнэлгүүдэд 38.2 тэрбум төгрөгийн татаас олгосон байна.

Дүрслэл 1.38

Нэгдсэн төсвийн орлого, зарлагын гүйцэтгэлийн жилийн өөрчлөлт



Эх сурвалж: Сангийн яам.


Тэмдэглэл: *-2016 оны эхний 4 сарын орлого, зарлагын гүйцэтгэлийн жилийн өөрчлөлт болно.

Төсвийн тэнцэл

2016 оны эхний 4 сард Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 663.6 тэрбум, улсын төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 748.9 тэрбум төгрөгийн тус тус алдагдалтай гарлаа. 2016 онд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцлийг -940.5 тэрбум төгрөг байхаар төсөвт тусгасан бөгөөд 2016 оны эхний 4 сарын гүйцэтгэл нь үүний 70.6 хувьтай тэнцэж байна. Хэрэв цаашид төсвийн алдагдал энэ хэмжээгээр өснө гэж үзвэл төсөвт тодотгол хийх зайлшгүй шаардлага үүсэхээр байна.

Дүрслэл 1.39

Нэгдсэн төсвийн тэнцлийн гүйцэтгэл (жил бүрийн эхний 4 сарын байдлаар, тэрбум төгрөг)



Эх сурвалж: Сангийн яам, Үндэсний статистикийн хороо.

Тэмдэглэл: Жил бүрийн эхний 4 сарын орлого, зарлага, тэнцвэржүүлсэн тэнцлийн гүйцэтгэл болон тэнцвэржүүлсэн тэнцлийн жилийн гүйцэтгэлийн тоон мэдээллийг ашиглав.

*2016 оны хувьд төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн жилийн төлөвлөгөөг ашиглав.


Тус хугацаанд гадаад зээлийн үндсэн төлбөрт 37.3 тэрбум, дотоод зээлийн үндсэн төлбөрт 25.8 тэрбум, Засгийн газрын богино хугацаат дотоод бондын үндсэн төлбөрт 200.0 тэрбум, урт хугацаат дотоод бондын үндсэн төлбөрт 436.3 тэрбум төгрөгийг тус тус төлж, 137.6 тэрбум төгрөгийн гадаад төслийн зээл, 1512.6 тэрбум төгрөгийн гадаад хөтөлбөрийн зээл авч, Засгийн газрын 587.0 тэрбум төгрөгийн богино хугацаат дотоод, 314.4 тэрбум

төгрөгийн урт хугацаат гадаад, 53.8 тэрбум төгрөгийн урт хугацаат дотоод бондыг тус тус арилжаалсан гүйцэтгэлтэй байна.

Шинээр гаргасан Засгийн газрын бонд, зээлийн багагүй хэсгийг үндсэн төлбөрт төлж байгаа нь Засгийн газар шинэ өр үүсгэх замаар хуучин өр төлбөрөө төлж буйг харуулж байна.

Дүрслэл 1.40

Засгийн газрын бонд ба зээл (шинээр гаргах, үндсэн төлбөр)



Эх сурвалж: Сангийн яам.


Тэмдэглэл: *Төлөвлөгөө

Тухайлбал, 2016 оны батлагдсан төсөвт Засгийн газрын шинээр авах зээл, шинээр гаргах бондын 87.2 хувийг Засгийн газрын зээл, бондын үндсэн төлбөрт төлөхөөр тусгасан байна.

2016 он гарсаар Монголбанкаар дамжин хийгддэг Засгийн газрын урт хугацаат бондын анхдагч зах зээлийн арилжаа эрс буурч, 2016 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 4 дүгээр сарын 20-ны өдөр хүртэлх хугацаанд 9 удаагийн арилжаагаар нийт 115 тэрбум төгрөгийн бонд арилжаалахаар зарласан боловч ердөө 500 сая төгрөгийн бонд арилжаалаад байна.

Дүрслэл 1.41

Засгийн газрын богино ба урт хугацаат бондын арилжаа



САНХҮҮГИЙН САЛБАР, ТҮҮНИЙ ДАРХЛАА

2.1 БАНКНЫ САЛБАРЫН ТӨЛӨВ БАЙДАЛ


БАНКНЫ САЛБАР

Ерөнхий төлөв байдал

Банкны салбарт 2016 оны эхний улирлын эцсийн байдлаар нийт 14 банк 1469 салбар нэгжтэйгээр үйл ажиллагаа явуулж байна. Нийт хадгаламж эзэмшигчдийн тоо 2.4 саяд, зээлдэгчдийн тоо 835.3 мянгад хүрлээ.

Дүрслэл 2.1

Банкны салбарын активын бүтэц



Эх сурвалж: Монголбанк.


Банкны салбарын нийт активын хэмжээ 2016 оны 4 дүгээр сарын байдлаар өмнөх оны мөн үеэс 8.4 хувиар буюу 1732.0 тэрбум төгрөгөөр өсч 22.2 их наяд төгрөг буюу ДНБ-ий 96¹⁷ хувьд хүрээд байна. Нийт активын бүтцийг авч үзвэл 52.0 хувь нь зээл, 11.4 хувь нь банкны нөөц, 11.3 хувь нь Засгийн газрын үнэт цаас, 1.2 хувь нь Төв банкны үнэт цаас, үлдэх 24.0 хувь нь бусад хөрөнгө байна.

¹⁷ ДНБ-ий 2015 оны гүйцэтгэлийг ашиглав.

Банкны салбарын нийт эх үүсвэрийн хэмжээ 2016 оны 4 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 8.5 хувиар өсч, 19.8 их наяд төгрөг байна. Нийт эх үүсвэрийн 12.0 хувийг харилцах, 38.3 хувийг хадгаламж, 18.4 хувийг гадаад пассив, 6.5 хувийг Засгийн газрын хадгаламж, үлдэх 24.7 хувийг бусад эх үүсвэр бүрдүүлж байна.

Дүрслэл 2.2

Банкны салбарын пассивын бүтэц



Эх сурвалж: Монголбанк.

Эх үүсвэр


Банкны салбарын нийт харилцах, хадгаламжийн 66.2 хувийг төгрөгийн, 33.8 хувийг валютын харилцах, хадгаламж бүрдүүлж байна. Гадаад валютын харилцах, хадгаламжийн нийт харилцах, хадгаламжид эзлэх хувийн жин өмнөх оны эцсээс 3.2 нэгж хувиар өссөн нь иргэд, аж ахуй нэгжүүдийн гадаад валютаар харилцах хадгаламжаа

байршуулах сонирхол бага зэрэг нэмэгдсэнийг харуулж байна.

Банкуудын эх үүсвэрийн өсөлтийн хурд нэмэгдэв. Монголбанкнаас мөнгөний уламжлалт бус бодлогын хүрээнд хэрэгжүүлсэн хөтөлбөрийн санхүүжилт болон харилцах хадгаламжийн тогтвортой өсөлттэй холбоотойгоор эх үүсвэрийн хэмжээ 2013 онд өсч байсан хэдий ч 2014 оноос хойш өсөлтийн хурд эргэн буурч, 2015 оны 1 дүгээр сард сөрөг утгатай болсон.

Дүрслэл 2.3

Банкны салбарын эх үүсвэрийн жилийн өсөлт



Эх сурвалж: Монголбанк.

2016 оны 4 дүгээр сарын байдлаар нийт пассивын жилийн өсөлт өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 15.5 нэгж хувиар өссөн бол нийт харилцах, хадгаламжийн жилийн өсөлт 7.5 хувьд хүрч өмнөх оны мөн үеэс 10.8 нэгж хувиар өсчээ.


Зээл

Зээлийн өсөлт саарсан хэвээр байна. Санхүүгийн салбарын нийт зээлийн багцын¹⁸ 96 орчим хувийг бүрдүүлж буй банкны зээлийн жилийн өсөлт 2016 он гарсаар үргэлжлэн саарсаар 4 дүгээр сард -5.5 хувьд хүрээд байна.

¹⁸ Арлжааны банк, ББСБ, ХЗХ-ны зээлийн өрийн үлдэгдлийн статистикт үндэслэн тооцов.

Дүрслэл 2.4

Банкны салбарын актив, зээлийн жилийн өсөлт




Эх сурвалж: Монголбанк.

Нийт зээлийг салбарын ангиллаар авч үзвэл, бөөний болон жижиглэн худалдаа, үл хөдлөх хөрөнгө, уул уурхай олборлолт, боловсруулах үйлдвэрлэлийн салбарт олгосон зээл өмнөх оны мөн үеэс буурсан бол барилга, бусад салбарт олгосон зээл өссөн байна.

Дүрслэл 2.5

Олгосон зээлийн жилийн өсөлт (салбараар)




Эх сурвалж: Монголбанк.

Зээлийн төвлөрлийн хэмжээ өндөр хэвээр байна. Банкны системийн хэмжээнд зээлийн төвлөрлийн эрсдэлд орох магадлал өндөр байгаа бөгөөд үүний шалтгаан нь манай орны эдийн засаг цөөн тооны салбараас өндөр хамааралтай байгаатай холбоотой юм. 2016 оны 1 дүгээр улирлын байдлаар банкны салбарын нийт зээлийн өрийн үлдэгдлийн 60.7 хувь уул уурхай, боловсруулах үйлдвэрлэл, барилга, үл хөдлөх хөрөнгө,

худалдаа зэрэг 5 салбарт төвлөрч байна. Иймд эдгээр салбаруудад хүндрэл үүсэхэд банкны салбарын зээлийн чанарт үзүүлэх сөрөг нөлөө нь өндөр юм.

Дүрслэл 2.6

Салбаруудын зээлийн төвлөрөл



Голлох салбарууд	Зээлийн өрийн үлдэгдэл (2016Q1)	Өмнөх оны мөн үеэс гарсан өөрчлөлт
Бөөний болон жижиглэн худалдаа	14.0%	-0.3%
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	12.7%	-3.0%
Барилга	13.0%	0.3%
Уул уурхай, олборлолт	10.1%	0.9%
Боловсруулах үйлдвэрлэл	10.9%	-0.2%
Бусад	39.3%	2.3%


Эх сурвалж: Монголбанк.

Тэмдэглэл: *Зээлийн багцад хамгийн өндөр жин эзэлж буй 4 салбарын зээлийн нийт дүнд эзлэх хувь.

Банкны салбарын зээлийн чанар муудаж байна. Нийт чанаргүй зээлийн хэмжээ энэ оны 4 дүгээр сарын байдлаар 1070.4 тэрбум төгрөгт хүрч (нийт зээлийн 9.3 хувь), өмнөх оны мөн үеэс 324.9 тэрбум төгрөгөөр буюу 43.6 хувиар өссөн¹⁹ бол хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл 908.5 тэрбум төгрөгт хүрч (нийт зээлийн 7.9 хувь) 55.1 хувиар нэмэгдлээ. Чанаргүй зээлийн өсөлт нь зээлийн эрсдэлийн сангийн зардлыг өсгөснөөр банкны салбарын өөрийн хөрөнгийн болон ашигт ажиллагааны үзүүлэлтүүдэд сөргөөр нөлөөлж байна.

Дүрслэл 2.7

Зээлийн чанарын үзүүлэлт, салбараар




Эх сурвалж: Монголбанк.

Уул уурхай, худалдаа, боловсруулах үйлдвэрлэлийн салбарын чанаргүй зээлийн хувь бусад салбаруудтай харьцуулахад өндөр буюу харгалзан 24.9, 12.6, 10.6 хувьтай байна. Үл хөдлөх хөрөнгийн салбарын чанаргүй зээлийн харьцаа харьцангуй бага байгаа боловч өнгөрсөн оны мөн үеэс 2.5 дахин өсчээ.

Дүрслэл 2.8

Хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн өсөлт



Голлох салбарууд	Нийт дүнд эзлэх хувь
Уул уурхай, олборлолт	31.4%
Бөөний болон жижиглэн худалдаа	15.4%
Боловсруулах үйлдвэрлэл	11.8%
Барилга	15.1%
Бусад	26.3%

Эх сурвалж: Монголбанк.


¹⁹ Татан буугдсан Анод, Зоос, Хадгаламж банкуудыг хасч тооцвол чанаргүй зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 64.2 хувиар өсч 834.0 тэрбум төгрөгт хүрсэн нь нийт зээлийн 7.4 хувьтай тэнцэж байна.

Банкны салбарын хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн 73.7 хувь нь уул уурхай, бөөний болон жижиглэн худалдаа, боловсруулах үйлдвэрлэл, барилгын салбаруудад төвлөрсөн бөгөөд нийт зээлийн өрийн үлдэгдлийн 47.9 хувийг дээрх 4 салбарт олгосон зээл бүрдүүлж байна.

Хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн өсөлт нь эдгээр салбаруудын эдийн засгийн идэвхжил суларч байгаатай холбоотой.

Дүрслэл 2.9

Хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээл (валютын төрлөөр)




Зээлийн чанарын үзүүлэлтүүд ийнхүү муудахад эдийн засгийн таагүй нөхцөл байдал болон гадаад валютаар олгосон зээлийн чанар муудсан нь голлон нөлөөлжээ.

2016 оны 4 дүгээр сарын байдлаар төгрөгийн чанаргүй зээлийн нийт төгрөгийн зээлд эзлэх хувь 7.5 хувь байхад валютын чанаргүй зээлийн нийт валютын зээлд эзлэх хувь 15.6 хувь буюу 2 дахин их байна.

Өрхийн бодит орлого сүүлийн 9 улирал дараалан буурав. Улсын хэмжээнд өрхийн сарын дундаж нэрлэсэн орлого 2016 оны эхний улиралд 10.9 хувиар, бодит орлого²⁰ 12.6 хувиар тус тус буурлаа.

Дүрслэл 2.10


Өрхийн бодит орлогын өсөлт



Бодит орлого буурах нь өрхийн бүтээгдэхүүн, үйлчилгээний хэрэглээг багасган, амжиргааны түвшинг бууруулах, улмаар зээлийн эргэн төлөлтийн чадавхийг сулруулах нөлөөтэй. 2016 оны эхний улиралд өрхийн нэрлэсэн зарлага өмнөх оны мөн үеэс 1.9 хувиар буурчээ.

Дүрслэл 2.11

Өрхийн орлого, зарлагын харьцаа




Зээлийн өсөлт саарч байгаатай холбоотойгоор хувийн салбарын болон өрхийн дотоод өрийн дарамт буурч байгаа бол гадаад өрийн дарамт өссөн хэвээр байна. Нэг өрхөд ногдох иргэдийн зээл 2016 оны эхний улиралд 5.8 саяд хүрч, сүүлийн 6 улирал дараалан буурав.

²⁰ Инфляци = 1.7 хувь

Дүрслэл 2.12

Өрхийн өрийн дарамт



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк.

Тэмдэглэл: *Нэг өрхөд ногдох иргэдийн зээлийн өрийн үлдэгдэл; **2009 оноос хойшхи өгөгдөл ашиглав.

***Нэг өрхөд ногдох иргэдийн зээлийн өрийн үлдэгдэлийг улсын дундаж өрхийн жилийн орлогод харьцуулж тооцов;


****Иргэдийн зээлийн өрийн үлдэгдэл ба нэрлэсэн ДНБ-ий харьцаа (жилийн ДНБ). Хамгийн сүүлийн утга нь 2016 оны I улирлын статистик болно.

Нэг өрхөд ногдох иргэдийн зээл ба өрхийн жилийн дундаж орлогын харьцаагаар өрхийн өрийн дарамтыг төлөөлүүлэн хэмжихэд тайлант улиралд өрхийн өрийн дарамт 45 хувьд хүрч буураад байна. Өрхийн өр төлбөрийг бүтцээр нь авч үзвэл ипотекийн зээлийн өрийн дарамтад эзлэх хувь 27.5 хувьд хүрсэн байна. Ипотекийн зээл нь хэрэглээг зохистой болгож, өрхийн хуримтлалыг нэмэгдүүлдэг тул макро эдийн засгийн тогтвортой байдалд урт хугацаанд эерэг нөлөөтэй юм.

Нэгж орлогод ногдох орон сууцны ипотекийн зээлийн төлбөрийн хувь хэмжээ буюу өр/орлогын харьцаа 2013 оны 3 дугаар улирал хүртэл буурсаар 38 хувьд хүрч байсан бол 2016 оны эхний улиралд 44 хувь болж аажмаар нэмэгдэх хандлагатай байна. Энэхүү харьцаа нь дундаж өрх орлогоороо орон сууцны ипотекийн зээл авсан бол өр, төлбөрийн хувьд ямар дарамттай байхыг илтгэнэ.

Дүрслэл 2.13

Өрхийн өр, орлогын харьцаа*




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк.

Тэмдэглэл: *Өрхийн дундаж орлогод эзлэх хувь бөгөөд энэхүү харьцааг тооцохдоо өрхийн орлогыг ҮСХ-ноос тооцон гаргадаг улсын өрхийн дундаж сарын орлогыг авч ашигласан болно. Харин орон сууцны зээлийн сарын төлбөрийг гаргахдаа 1 зээлдэгчийн орон сууцны дундаж зээлийн хэмжээ, жигнэсэн дундаж хугацаа, хүүг ашигласан болно.

Хувийн салбарын өрийн дарамтыг аж ахуйн нэгжийн дотоод зээл ба гадаад өр төлбөрийн ДНБ-д эзлэх хувиар төлөөлүүлэн хэмжиж болно. 2005 оноос хойш гадаад өрийн дарамт хурдтай өссөөр байгаа бөгөөд 2016 оны эхний улиралд хувийн салбарын гадаад өр ДНБ-ий 45.2 хувьд хүрээд байна. Харин хувийн салбарын дотоод өр ДНБ-ий 26.7 хувьд хүрч буурав.

Дүрслэл 2.14

Хувийн салбарын өрийн дарамт



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк.

Тэмдэглэл: *Аж ахуйн нэгжийн зээлийн өрийн үлдэгдэл ба нэрлэсэн ДНБ-ий харьцаа (жилийн ДНБ);


**Хувийн салбарын гадаад зах зээлээс зээлдсэн эх үүсвэр (өрийн бичиг, зээл, бусад өглөг) ба нэрлэсэн ДНБ-ий харьцаа (жилийн ДНБ).

Орон сууцны үнэ үргэлжлэн буурсаар байна. Орон сууцны үнийн индексийг

Үндэсний статистикийн хороо 2007 оноос, Монголбанкнаас 2013 оноос тус тус тооцож эхэлсэн билээ. 2014 оноос эхлэн орон сууцны үнийн өсөлт саарч эхэлсэн бөгөөд 2016 оны эхний улиралд жилийн 11.6 хувийн бууралттай гарчээ. Манай улсад зээл үнэлгээний харьцаа (loan to value ratio) 70 хувьтай мөрдөгдөж байна. Өөрөөр хэлбэл зээлдэгч 30 хувийн урьдчилгаа төлж, үлдсэн 70 хувьтай тэнцэх хэмжээний зээлийг банкнаас авах боломжтой юм.

Дүрслэл 2.15

Орон сууцны үнэ, ипотекийн зээлдэгчдийн тооны жилийн өөрчлөлт



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк.

Тэмдэглэл: Хамгийн сүүлийн утга нь 2016 оны 1 дүгээр улирлын статистик болно.

Өөрийн хөрөнгө


Банкны салбарын өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт сайжрав. Монголбанкнаас 2014 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг 50 тэрбум болгох шийдвэр гаргасан. Ингэснээр банкуудын өөрийн хөрөнгийн хүрэлцээ нэмэгдэж, эрсдэл даах чадвар сайжирч байна.

Эдийн засгийн нөхцөл байдал хүндрэлтэй, чанаргүй болон хугацаа хэтэрсэн зээлийн хэмжээ нэмэгдсэн хэдий ч банкны салбарын зохистой харьцааны үзүүлэлтүүд тогтвортой хэвээр байна. Банкны системийн эрсдэл даах чадварыг тодорхойлдог өөрийн хөрөнгийн

хэмжээ 4 дүгээр сарын эцсийн байдлаар 2.4 их наяд төгрөгт хүрч өмнөх оны эцсээс 7.7 хувиар буюу 174.2 тэрбум төгрөгөөр өслөө.

Дүрслэл 2.16

Өөрийн хөрөнгийн үзүүлэлтүүд



Эх сурвалж: Монголбанк.


Банкны салбарын нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 13.2 хувь, нийт өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 17.7 хувь байгаа нь Монголбанкнаас тогтоосон шалгуур үзүүлэлтээс харгалзан 4.2 ба 5.7 нэгж хувиар тус тус өндөр байгаа бөгөөд өмнөх оны мөн үеэс харгалзан 0.9, 0.5 нэгж хувиар сайжирсан байна.

Ашигт ажиллагаа

Банкны салбарын ашигт ажиллагаа буурч байна.

Дүрслэл 2.17

Банкны актив болон өөрийн хөрөнгийн өгөөж




Эх сурвалж: Монголбанк.

Банкуудын зээлийн эргэн төлөлт удааширч, зээлийн чанар муудаж байгаа нь банкны салбарын ашигт ажиллагаанд сөргөөр нөлөөлж байна.

Банкны салбар тайлант оны эхнээс 4 сарын турш алдагдалтай ажилласан бөгөөд зээлийн чанар муудсантай холбоотойгоор 2016 оны эхнээс нийт 85.7 тэрбум төгрөгийн зээлийн эрсдэлийн сан байгуулсан нь банкны ашигт ажиллагааны үзүүлэлтүүд муудахад нөлөөллөө.

Дүрслэл 2.18

Зээлийн эрсдэлийн сангийн өсөлт



Эх сурвалж: Монголбанк, Арилжааны банкуудын нэгдсэн тайлан.

Гадаад валютын позиц

2016 оны эхний улирлын байдлаар банкны салбарын гадаад валютын зохистой харьцааны үзүүлэлт нэгж валютын хувьд ч, нийт валютын хувьд ч Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж байна.²¹ Нийт гадаад валютын активын хэмжээ 6.1 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 3.6 хувиар буурсан бол гадаад валютын пассивын хэмжээ 8.4 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 11.0 хувиар өссөн нь банкууд гадаад валютаар эх үүсвэр татах нь нэмэгдэж байгаа хэдий ч


гадаад валютаар зээл олгохоо бууруулж буйг харуулж байна.

Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар

2014 оны эхэн үеэс банкны салбарын үндсэн эх үүсвэр болох харилцах, хадгаламжийн өсөлт саарахын зэрэгцээ Монголбанкны хөтөлбөрийн зээлүүд эргэн төлөгдөхийн хэрээр Төв банкнаас арилжааны банкуудад олгосон зээлийн үлдэгдэл буурсан нь банкны салбарын нийт эх үүсвэр 2015 онд буурахад голлон нөлөөлсөн. Харин эх үүсвэр 2016 оны 4 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 8.5 хувиар өсч 19.8 их наяд төгрөгт хүрээд байна.

Дүрслэл 2.19

Банкны салбарын актив, пассивт гарсан өөрчлөлт (2015.04-2016.04)



Эх сурвалж: Монголбанк.


Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар нь банкны системийн тогтвортой байдлыг илтгэдэг үндсэн үзүүлэлтүүдийн нэг бөгөөд харилцагчийн анхны шаардлагаар төлбөрийг түргэн түргэн гүйцэтгэх чадварыг илэрхийлдэг. 2016 оны 4 дүгээр сарын байдлаар банкны системийн хэмжээнд төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа 39.7 хувь буюу Монголбанкнаас тогтоосон зохистой

²¹ Банкууд гадаад валютын нээлттэй позиц, өөрийн хөрөнгийн харьцааг нэг валютын хувьд +/-15 хувийн дотор, нийт нээлттэй позицийн хувьд +/-40 хувийн дотор барьж байх шаардлагатай.

харьцааны үзүүлэлтээс (25 хувь) 14.7 хувиар илүү байна.

Дүрслэл 2.20

Банкны салбарын төлбөр түргэн гүйцэтгэх чадвар




Эх сурвалж: Монголбанк.

Зээл, хадгаламжийн зохистой харьцааны талаарх олон улсын судалгаанаас үзэхэд энэхүү харьцаа 120 хувиас хэтрэх нь банкны салбар төлбөрийн чадварын эрсдэл дээр анхаарал хандуулах хэрэгтэй болсныг сануулдаг байна.²²

Дүрслэл 2.21

Хөрвөх чадварын үзүүлэлт



Эх сурвалж: Монголбанк.

Тэмдэглэл: * (Банкны нөөц+ТБҮЦ)/(Харилцах+Хадгаламж).


** (Банкны нөөц+ТБҮЦ+ЗГ-ын богино хугацаатай үнэт цаас)/(Харилцах+Хадгаламж).

Харин манай орны хувьд уг үзүүлэлт 104.9 хувьтай байна.

²² Jan Willem van den End, "A macroprudential approach to address liquidity risk with the Loan-to-deposit ratio" DNB Working Paper, No. 372, Feb 2013.

Дүрслэл 2.22

Зээл, хадгаламжийн харьцаа



Эх сурвалж: Монголбанк.

МАКРО ЗОХИСТОЙ БОДЛОГО, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТ

Сүүлийн жилүүдэд санхүүгийн системийн эрсдэлийг бууруулах, эдийн засгийн мөчлөгийн далайцыг багасгах зорилгоор мөчлөг сөрсөн, эрсдэлд суурилсан микро хяналт шалгалт болон макро зохистой бодлогын цогц арга хэрэгслүүдийг нэвтрүүлэн ашиглаж байна.

Монголбанкнаас банкны салбарын эрсдэл даах чадварыг сайжруулах хүрээнд 2015-2016 онд дараах бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлээд байна. Үүнд:

- ♦ **Банкуудын хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг 50 тэрбум төгрөг болгон нэмэгдүүллээ.** Монголбанкны Ерөнхийлөгчийн 2015 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн А-58 дугаар тушаалаар банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг 50 тэрбум төгрөг байхаар шинэчлэн тогтоолоо. Энэхүү шаардлагыг биелүүлэх хугацааг эдийн засгийн нөхцөл байдал, банкны төлбөрийн чадвар, үйл ажиллагааны онцлог, систем дахь өрсөлдөөний хандлагыг харгалзан банк бүрээр харилцан адилгүй тогтоож, 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг эцсийн хугацаа байхаар шийдвэрлэсэн болно. Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг 1991 онд 50 сая төгрөгөөр анх тогтоож эхэлсэн бол 1995 онд 400 сая төгрөг, 1999 онд 2 тэрбум төгрөг, 2001 онд 4 тэрбум төгрөг, 2006 онд 8 тэрбум төгрөг, 2011 онд 16 тэрбум төгрөгөөр тус тус тогтоож байсан. Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийг ийнхүү нэмэгдүүлснээр банкны салбарын эрсдэл даах чадвар сайжрахын зэрэгцээ банкуудын томоохон төслүүдийг бие даан санхүүжүүлэх чадавхийг нэмэгдүүлэх, хувь нийлүүлэгчдийн санхүүгийн хариуцлагыг дээшлүүлэх,

цаашлаад жижиг банкуудын үйл ажиллагааг идэвхжүүлэн банкны салбарт шударга өрсөлдөөнийг бүрэлдүүлэх зэрэг олон давуу талыг бий болгоно.

- ♦ **Санхүүгийн салбарын активын удирдлагын бүтцийг төрөлжүүлэх, хоёрдогч зах зээлийг хөгжүүлэх ажлыг эхлүүлээ.** Тайлант онд активын удирдлагын үр ашигтай, байнгын ажиллагаатай тогтолцоог бүрдүүлэхэд Монголбанкны баримтлах бодлого, оролцоо, үүсгэн байгуулагдах институцийн бүтэц, зохион байгуулалтын судалгааг гүйцэтгэж, хувийн салбарын оролцоотой Активын удирдлагын компанийг үүсгэн байгуулах саналыг 2015 оны 10 дугаар сард банкуудад танилцуулсан. Улмаар хамтран ажиллах ерөнхий гэрээг байгуулан, компанийг үүсгэн байгуулах гэрээ, дүрмийг боловсруулан, үүсгэн байгуулагчийн анхдугаар хурлыг хуралдуулж, Төлөөлөн удирдах зөвлөлийг бүрдүүлээд байна. Мөн Активын удирдлагыг үр ашигтай гүйцэтгэхэд шаардлагатай эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор Азийн хөгжлийн банкнаас санхүүгийн болон техник туслалцаа авахаар тохиролцож харилцан ойлголцлын санамж бичиг байгуулан, цаашид энэ чиглэлд хамтран ажиллахаар болоод байна.
- ♦ **Банкны нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэв.** Банкны санхүүгийн тайлагналыг Олон Улсын нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцүүлэх зорилгоор сүүлийн 3 жилд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнд 2015 оны 2 дугаар сард Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайд хамтран

“Банкны нягтлан бодох бүртгэлийн багц материал”-ыг шинэчилсэн баталсан. Энэ багц материалд нийцүүлэн банкны сарын тайлангийн шинэ загварыг турших, сайжруулах, мэдээллийн агууллагыг баяжуулах үйл ажиллагааг 2015 онд банкуудтай хамтран гүйцэтгэсэн бөгөөд 2016 оны эхнээс Олон Улсын нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тайланд үндэслэн банкуудын эрсдэл даах чадварыг үнэлж эхлээд байна.

- ♦ **Чанаргүй активыг тэнцлээс хасах эрх зүйн орчныг сайжрууллаа.** Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн Сайдын 2015 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн А-182/324 дүгээр хамтарсан тушаалаар “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-д өөрчлөлт оруулан банкууд муу активыг тэнцлээс хасахдаа шүүхийн шийдвэрт үндэслэдэг байсан зохицуулалтыг өөрчлөн Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр хасах боломжийг нээлээ. Ингэснээр цаашид төлөгдөхгүй нь тодорхой болсон, төлбөр хариуцагч нь сураггүй болсон зэрэг зээлийг тэнцлээс шуурхай хасах боломжтой болж банкны зардлыг бууруулах боломж бүрдсэн.
- ♦ **Эрсдэлийн үнэлгээнд суурилсан хяналт шалгалтын аргачлалыг хөгжүүлэх арга хэмжээг үргэлжлүүлж байна.** Хяналт шалгалтын аргачлалыг гүйцэтгэлд суурилсан аргачлалаас эрсдэлийн үнэлгээнд суурилсан хяналт шалгалтын аргачлалд шилжүүлэн, хяналт шалгалтын нөөцийг оновчтой хуваарилах, хүлээж болзошгүй эрсдэлийг урьтаж илрүүлэх, бодлогын арга хэмжээг тухай бүр авах замаар системийн эрсдэлийг бууруулахад Монголбанкнаас онцгой анхаарал хандуулж байна. Энэ арга хэмжээний хүрээнд тайлант онд банкинд газар дээрх

хяналт шалгалт хийх аргачлалыг боловсронгуй болгох судалгааг гүйцэтгэн, эрсдэлд суурилсан аргачлалд тулгуурласан журмыг боловсруулан Монголбанкны Ерөнхийлөгчийн 2016 оны 3 дугаар сарын 1-ний өдрийн А-61 дүгээр тушаалаар батлан, үйл ажиллагаандаа мөрдөж эхлээд байна.

2.2 БАНКНЫ БУС САНХҮҮГИЙН САЛБАРЫН ТӨЛӨВ БАЙДАЛ

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА, ХАДГАЛАМЖ ЗЭЭЛИЙН ХОРШОО


Банк бус санхүүгийн байгууллагын өнөөгийн байдал

Ерөнхий төлөв байдал

2016 оны эхний улирлын байдлаар нийт 463 ББСБ Хорооноос олгосон тусгай зөвшөөрөлтэйгөөр банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхэлж байна.

Дүрслэл 2.23

Бүртгэлтэй банк бус санхүүгийн байгууллагын тоо



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

Банкуудын зээлийн нөхцөл чангарсантай холбоотойгоор иргэд, аж ахуйн нэгжүүд банк бус санхүүгийн байгууллагуудад хандан хурдан шуурхай зээл авах ажиллагаа идэвхжсэн нь сүүлийн жилд банк бус санхүүгийн байгууллагуудын тоо өсгөх үндсэн шалтгаан болов. ББСБ-уудын 2015 болон 2016 оны эхний улирлын эцсийн байдлаарх голлох үзүүлэлтүүдийг Хүснэгт 2.1-т хураангуйлан харууллаа.

Хүснэгт 2.1

Банк бус санхүүгийн байгууллагын голлох статистик үзүүлэлтүүд (тэрбум төгрөг)

№	Үндсэн үзүүлэлтүүд	2015Q1	2016Q1
1	ББСБ-ын тоо	395	463
2	Хувьцаа эзэмшигчдийн тоо	830	904
3	Ажиллагсадын тоо	1 623	2 000
4	Салбар нэгжийн тоо	109	121
5	Харилцагчдын тоо	405 558	445 918
6	Нийт актив	516	634
	Банкны салбарт эзлэх хувь	2.5%	2.9%
7	Нийт зээлийн өрийн үлдэгдэл	332	401
	Банкны салбарт эзлэх хувь	2.8%	3.5%
8	Нийт эзэмшигчдийн өмч	337	456
	Банкны салбарт эзлэх хувь	14.1%	17.5%
9	Итгэлцлийн үйлчилгээний өглөг	28	29
10	Банк, банк бус санхүүгийн байгууллагаас татсан зээл	121	111
	Үүнээс:		
	Богино хугацаат зээл	63	59
	Урт хугацаат зээл	57	52
11	Төслийн зээлийн санхүүжилт	13	15
12	Нийт орлого	37	41
13	Нийт зардал	28	34
14	Тайлант үеийн ашиг	9	13

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

Нийт ББСБ-ын 88.3 хувь нь зээл, 30.2 хувь нь гадаад валютын арилжаа, 6.9 хувь нь хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх, 1.5 хувь нь цахим төлбөр тооцоо мөнгөн гуйвуулгын үйлчилгээ, 4.3 хувь нь факторингийн үйлчилгээ, 2.8 хувь нь төлбөрийн баталгаа гаргах, 5.8 хувь нь итгэлцлийн үйлчилгээ, 0.2 хувь нь богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх үйлчилгээг тус тус эрхлэн явуулж байна.

Хүснэгт 2.2

Банк бус санхүүгийн байгууллагын эрхэлж буй үйл ажиллагааны төрөл

№	Үйл ажиллагааны нэр төрөл	2015Q1	2016Q1
1	Зээл	349	409
2	Гадаад валютын арилжаа	137	140
	Үүнээс: зөвхөн гадаад валютын арилжааг дагнан эрхэлдэг	53	51
3	Итгэлцлийн үйлчилгээ	2	1
4	Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх	53	26
5	Факторингийн үйлчилгээ	51	17
6	Төлбөрийн баталгаа гаргах	0	0
7	Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ	24	27
8	Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх	25	32
9	Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах	6	7
	Үл хөдлөх эд хөрөнгө барьцаалахтай холбоотой санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа	0	0


Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

Нийт актив

2007 хойш нийт актив жил бүр өсөн нэмэгдсээр 2016 оны эхний улирлын эцэст 634 тэрбум төгрөгт хүрсний 609 тэрбум төгрөг нь эргэлтийн хөрөнгө байна.

Дүрслэл 2.24

Банк бус санхүүгийн байгууллагын нийт хөрөнгийн бүтэц (тэрбум төгрөг)



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

Зээлийн чанар


2016 оны эхний улирлын эцсийн байдлаар зээлийн багц нийт активын 63.1 хувь буюу 400.5 тэрбум төгрөг байгаа нь өмнөх оны мөн үеэс 20.6 хувиар өссөн дүнтэй байна. Энэхүү өсөлтийн 12.4 нэгж хувь нь хэвийн зээлийн

өсөлт, 1.7 нэгж хувь нь хугацаа хэтэрсэн зээлийн өсөлт, 6.4 нэгж хувь нь чанаргүй зээлийн өсөлтөөр тайлбарлагдаж байна.

2016 оны эхний улиралд чанаргүй зээлийн хэмжээ өмнөх оны эцсээс 19.3 хувиар өсч 45.7 тэрбум төгрөгт хүрэв. Чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь 11.4 хувь байгаа нь банкны салбартай харьцуулахад 3.2 нэгж хувиар өндөр байгаа юм.²³ Чанаргүй зээлийн хэмжээ цаашид ч өсөх хандлагатай байгаа ба эдийн засгийн өсөлт саарснаас шалтгаалан иргэд, аж ахуй нэгж байгууллагын орлого буурч буй өнөөгийн нөхцөлд их хэмжээгээр өндөр хүүтэй зээл олгох нь уг салбар дахь зээлийн эрсдэлийг нэмэгдүүлж болзошгүй юм.

Дүрслэл 2.25

Банк бус санхүүгийн байгууллагын нийт зээл, зээлийн чанар (тэрбум төгрөг)



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

Нийт эх үүсвэр ба Эзэмшигчдийн өмчийн бүтэц

2016 оны эхний улирлын эцэст өмнөх оны эцэстэй харьцуулахад эзэмшигчдийн өмч 7.4 хувиар өссөн байна. 2015 оны эцэст нийт эх

²³ Анод, Зоос, Хадгаламж зэрэг татан буугдсан банкуудын чанаргүй зээлийг оруулж тооцсон чанаргүй зээл нийт зээлийн харьцаа 2016 оны эхний улирлын эцэст 8.2 хувь байгаа ба харин хасч тооцвол 6.3 хувь байна.

үүсвэрийн 28.2 хувийг өр төлбөр, 68.1 хувийг эзэмшигчдийн өмч эзэлж байсан бол 2016 оны эхний улирлын байдлаар 25.3 хувийг өр төлбөр, эзэмшигчийн өмч 71.8 хувь болж өөрчлөгдсөн.

Хүснэгт 2.3

Банк бус санхүүгийн байгууллагын санхүүгийн голлох үзүүлэлтүүд (тэрбум төгрөг)

Үзүүлэлт	2010	2011	2012	2013	2014	2015	2016Q1
Нийт актив	128.6	205.4	252.1	381.1	508.0	623.1	634.1
Нийт олгосон зээл	78.1	119.0	157.8	223.7	303.1	391.2	400.5
Нийт өр төлбөр ба эзэмшигчдийн өмч	128.6	205.4	252.1	381.1	508.0	623.1	634.1
Нийт өр төлбөр	36.6	67.2	80.7	146.8	175.9	175.6	160.5
Эзэмшигчдийн өмч	92.0	138.2	171.3	234.3	332.1	424.2	455.5
Үүнээс:							
Хувьцаат капитал	80.0	116.5	137.9	183.7	258.2	308.4	341.2
Бусад өмч	0.5	3.2	7.6	7.2	7.2	12.0	11.2
Сангууд	1.1	1.1	0.1	0.2	0.3	0.3	0.5
Хуримтлагдсан ашиг/алдагдал	9.4	14.7	24.2	41.7	64.0	102.0	101.7
Хоёрдогч өглөг	0.9	2.7	1.6	1.6	2.4	1.4	0.8
Нийт орлого	30.1	46.3	70.5	106.6	132.9	156.3	41.0
Нийт зарлага	22.9	34.9	51.9	76.8	96.5	110.0	33.9
Татварын дараах цэвэр ашиг	7.1	11.4	18.6	29.8	36.4	46.3	12.7

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

ББСБ-ын тоо өсөн нэмэгдэхийн хэрээр хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ өсчээ. 2016 оны эхний улирлын эцсийн байдлаар хувь нийлүүлсэн хөрөнгө өмнөх оны эцсээс 32.8 тэрбум төгрөгөөр буюу 10.6 хувиар өссөн байна.

Орлого, зарлага, ашигт ажиллагаа

Тайлант хугацаанд салбарын хэмжээнд нийт 41 тэрбум төгрөгийн орлоготой ажиллав. Нийт орлогын 81.5 хувийг хүүгийн орлого, 16.6 хувийг хүүгийн бус орлого тус тус эзэлж байна. Харин ашигт ажиллагааны гол үзүүлэлт болох ROA (активын өгөөж) 2016 оны эхний улирлын эцсийн байдлаар 2.0 хувь байгаа нь банкны салбартай харьцуулахад өндөр байгаа юм.

Хүснэгт 2.4

Орлого, зарлага, ашигт ажиллагаа (тэрбум төгрөг)

№	Үзүүлэлтүүд	2016Q1
1	Нийт орлого	41.0
	Хүүгийн орлого	33.4
	Хүүгийн бус орлого	6.8
	Үндсэн бус үйл ажиллагааны орлого	0.7
2	Нийт зардал	28.2
	Хүүгийн зардал	4.3
	Хүүгийн бус зардал	16.5
	Болзошгүй эрсдэлийн зардал	5.6
	Үндсэн бус үйл ажиллагааны зардал	0.2
3	Орлогын татварын зардал	1.6
4	Татварын дараах цэвэр ашиг	12.7

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

ББСБ-уудын зохистой харьцааны үзүүлэлт

СЗХ-ны 191 дүгээр тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”-аар тогтоосон үзүүлэлтүүдийг 2016 оны эхний улирлын эцсийн байдлаар системийн түвшинд тооцоход нийт системийн дүнгээр бүх шаардлагат зохистой харьцааны түвшинг ханган ажиллаж байна.

Хүснэгт 2.5

ББСБ-уудын зохистой харьцааны үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Зохистой харьцааны шаардлагат түвшин	2016Q1
1. Өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт		
-Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жинлэсэн активын харьцаа	10%<=	84.4%
-Өөрийн хөрөнгө, эрсдэлээр жинлэсэн активын харьцаа	20%<=	85.0%
-Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа	10%<=	67.8%
2. Итгэлцлийн үйлчилгээний өглөг, хувьцаат капиталын үзүүлэлт		
-Итгэлцлийн үйлчилгээний өглөг ба хувьцаат капиталын харьцаа	80%>=	6.4%
3. Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар		
-Түргэн борлогдох актив, бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн харьцаа	8%<=	103.9%
4. Үндсэн хөрөнгийн үзүүлэлт		
-Цэвэршүүлсэн үндсэн хөрөнгийн дүн ба нийт активын харьцаа	15%>=	1.8%

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.


Хадгаламж, зээлийн хоршооны өнөөгийн байдал

Ерөнхий төлөв байдал

2016 оны эхний улирлын байдлаар 271 Хадгаламж, зээлийн хоршоо СЗХ-ноос олгосон тусгай зөвшөөрөлтэйгөөр хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж байна.

Дүрслэл 2.26

Хадгаламж, зээлийн хоршоо болон гишүүдийн тоо



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

Хадгаламж, зээлийн хоршоодын активын хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 18.4 хувиар өсч 101.5 тэрбум төгрөгт хүрэв.

Хүснэгт 2.6

Хадгаламж, зээлийн хоршоодын голлох статистик үзүүлэлтүүд (тэрбум төгрөг)

№	Үндсэн үзүүлэлтүүд	2016Q1
1	ХЗХ-дын тоо	271
2	Гишүүдийн тоо	41 817
3	Нийт актив	101.5
	Банкны салбарт эзлэх хувь	0.5%
4	Нийт зээлийн өрийн үлдэгдэл	80.3
	Банкны салбарт эзлэх хувь	0.7%
5	Нийт чанаргүй зээлийн үлдэгдэл	3.4
	Банкны салбарт эзлэх хувь	0.4%
6	Нийт татан төвлөрүүлсэн хадгаламжийн үлдэгдэл	62.8
	Банкны салбарт эзлэх хувь	0.8%
7	Нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн үлдэгдэл	11.1
	Банкны салбарт эзлэх хувь	
8	Нийт хоршоологчдын өмчийн үлдэгдэл	9.3
9	Бусад өр төлбөр	18.2
10	Нийт орлого	6.0
11	Нийт зардал	5.4
12	Тухайн үеийн ашиг, алдагдал	0.6


Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

Зээлийн чанар

Тайлант хугацаанд нийт зээлийн багцын 91.3 хувь нь хэвийн зээл, 4.5 хувь нь хугацаа хэтэрсэн зээл, 4.2 хувь нь чанаргүй зээл тус тус эзлэв. Чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь 2015 оны эцсээс 0.4 нэгж хувиар буурч 4.2 хувьд хүрчээ.

Дүрслэл 2.27

Хадгаламж, зээлийн хоршоодын нийт зээл, зээлийн чанар (тэрбум төгрөг)




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

Өр төлбөр ба өөрийн хөрөнгө

ХЗХ-дын өр төлбөр, өөрийн хөрөнгийн хэмжээ өмнөх оны эцсээс 3.7 тэрбум төгрөгөөр буюу 3.8 хувиар өссөн. Татан төвлөрүүлсэн хадгаламжийн хэмжээ 62.8 тэрбум төгрөг буюу нийт эх үүсвэрийн 61.9 хувийг эзэлж байна.

Дүрслэл 2.28

Хадгаламж, зээлийн хоршоодын өр төлбөр ба өөрийн хөрөнгө (тэрбум төгрөг)



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

Ашигт ажиллагаа

2016 оны эхний улирлын эцэст ХЗХ-дын нийт орлого 6.0 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеийнхээс 1.0 тэрбум төгрөг буюу 83.3 хувиар өссөн бол нийт зардал 5.4 тэрбум төгрөгт хүрч, мөн 83.3 хувиар өссөн дүнтэй

гарсан. Ингэснээр тайлант хугацаанд нийт цэвэр ашгийн хэмжээ 0.6 тэрбум төгрөгт хүрч, өнгөрсөн оны мөн үеийнхтэй харьцуулахад 80.6 хувиар өсөв. Ийнхүү ашиг өсөхөд болзошгүй эрсдэлийн сангийн зардал 46.2 хувиар буурсан нь голлон нөлөөлөв.

ХЗХ-дын эмзэг байдал

Хэдийгээр болзошгүй эрсдэлийн сангийн зардал буурсан хэдий ч, нийт чанаргүй зээлийн хэмжээ 3.4 тэрбум төгрөгөөр буюу 78.9 хувиар өссөн байна. Мөн эдийн засгийн өсөлт саарч байгаатай холбоотойгоор ХЗХ-дын гишүүдийн орлогын эх үүсвэр тасалдах, буурах зэрэг хүчин зүйлс чанаргүй зээлийн хэмжээ өсөхөд нөлөөлж, олгогдсон зээл хугацаандаа төлөгдөхгүй байх эрсдэл үүсч байгаа тул ХЗХ-дод тавигдах шалгуурыг өндөрсгөх, тэдгээрийг чадавхижуулах, хяналт шалгалтын оновчтой хэрэгжүүлэхэд анхаарах шаардлагатай байна.


ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ**Ерөнхий төлөв байдал****Зах зээлийн үнэлгээ**

Үнэт цаасны зах зээлийн эдийн засагт эзлэх хувийг зах зээлийн үнэлгээ (ЗЗҮ)-гээр илэрхийлэх ба 2016 оны эхний улирлын эцсийн байдлаар ЗЗҮ 1 их наяд 297.3 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны эцсээс 1.0 хувиар буурсан үзүүлэлт боллоо.

Зах зээлийн үнэлгээ буурахад эдийн засгийн өсөлт удааширсан, уул уурхайн салбарын компанийн хувьцааны үнэ ханш дотоодын болон олон улсын хөрөнгийн бирж дээр огцом буурсан, гадаадын хөрөнгө оруулагчдын үнэт цаасны зах зээлд хөрөнгө оруулах сонирхол 2012 оноос хойш эрс буурсан, зах зээлийн дэд бүтэц сул зэрэг нь голчлон нөлөө үзүүлжээ.

Дүрслэл 2.29

ТОП-20 индекс болон зах зээлийн үнэлгээ



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

Тайлант хугацаанд ТОП-20 индексийн дээд үзүүлэлт 12685.9 нэгж, доод үзүүлэлт 10673.1 нэгж, дундаж үзүүлэлт 11712.4 нэгж байв.

ТОП-20 индексийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 16.2 хувиар буурсан байна.

Үнэт цаасны арилжааны үзүүлэлтүүд

Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн 60 удаагийн хувьцааны арилжаагаар нийт 91 компанийн 36.1 сая ширхэг хувьцааг 8.3 тэрбум төгрөгөөр арилжсанаас 74.9 хувь буюу 6.26 тэрбум төгрөгийн гүйлгээг хувьцааны анхдагч зах зээл, 3.15 хувь буюу 263.6 сая төгрөгийн гүйлгээг багцын арилжаа, үлдэх 21.95 хувь буюу 1.83 тэрбум төгрөгийн гүйлгээг энгийн арилжаа тус тус бүрдүүллээ. Хувьцааны арилжааны үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 26 компанийн үнэт цаасны үнэ өсч, 61 компанийн ханш буурч, 3 компанийн үнэт цаасны ханш тогтмол байлаа. Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаагаар “Монгол Шуудан”ХК-ийн үнэт цаасны 34 хувь буюу 33.8 сая ширхэг хувьцаа 6.26 тэрбум төгрөгөөр

арилжигдсан нь нийт хувьцааны арилжааны үнийн дүнгийн 74.9 хувийг эзэлж байна.

Тайлант хугацаанд “Монголын хөрөнгийн бирж” ХК дээр ЗГҮЦ-ны анхдагч зах зээлийн арилжаа 12 удаа явагдаж, 12, 28, 39, 52 долоо хоногийн хугацаатай нийт 392.9 мянган ширхэг үнэт цаас 37.4 тэрбум төгрөгөөр арилжаалагдсан бол хоёрдогч зах зээлийн арилжаагаар 38.7 мянган ширхэг үнэт цаасыг 3.8 тэрбум төгрөгөөр арилжсан байна. Нийт ЗГҮЦ-ны арилжааны 84.9 хувийг Монголбанкаар, үлдсэн 15.1 хувийг “Монголын хөрөнгийн бирж” ХК-иар дамжин хийгдсэн байна.

СЗХ-ны 2016 оны 2 дугаар тогтоолоор “МИК Актив Найм” ХХК-ийн 1.9 сая ширхэг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг бүртгэсэн ба 8 удаагийн үнэт цаасжуулалт хийгдсэнээс нийт 1787.1 тэрбум төгрөгийн үндсэн төлбөр төлөгджээ.

Үнэт цаасны зах зээлийн дэд бүтцийн үзүүлэлтүүд

Бүртгэлтэй компани

2016 оны эхний улиралд 1 компани олон нийтэд үнэт цаасаа анх удаа санал болгон гаргаж нээлттэй компанийн хэлбэрт шилжсэнээр нийт 300 компани СЗХ-ны үнэт цаасны дэлгэрэнгүй бүртгэлд бүртгэлтэй байна.

Хөрөнгийн биржид бүртгэлтэй хувийн өмчит компаниудын дийлэнх нь өмч хувьчлалаар үүсэн бий болсноос үүдэн компанийн хувьцааны хяналтын багц цөөн тооны нэгдмэл сонирхолтой этгээдүүдийн гарт төвлөрсөн нь зах зээл дэх нийлүүлэлтэд сөргөөр нөлөөлж ирэв.

Дүрслэл 2.30

Хувьцаат компанийн тоо



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

Хувьцаат компанийн хяналтын багц цөөн тооны хөрөнгө оруулагчдын гарт төвлөрсөн нь компанийн засаглал сул, дотоод мэдээлэл эзэмшигч этгээд үнэт цаасны үнэ ханшид

нөлөөлөх, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын хөрөнгө оруулах сонирхлыг бууруулж, зах зээлийн хөрвөх чадварыг бууруулах үндсэн шалтгаан болж байна.

2010 онд Компанийн тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсантай холбоотойгоор СЗХ-ны зүгээс компанийн засаглалыг сайжруулах чиглэлээр тодорхой зохицуулалтын эрх зүйн орчинг бүрдүүлж байгаа хэдий ч, хувийн өмчит хувьцаат компанийн дийлэнх хувь нь 75 буюу түүнээс дээш хувийн төвлөрөлтэй, хяналтын багц цөөн тооны нэгдмэл сонирхолтой этгээдүүдийн гарт төвлөрсөн байгаа өнөөгийн нөхцөлд хувьцаа эзэмшигчдийн хурал нэр төдий хуралдах, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашиг зөрчигдөх, ТУЗ-ийн

хараат бус гишүүнийг нэр төдий сонгох, их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийж компанийн өмч хөрөнгийг үрэгдүүлэх явдал хэвээр байна.

Зах зээлийн дэд бүтэц

2016 оны эхний улирлын эцсийн байдлаар Хорооноос олгосон тусгай зөвшөөрөл бүхий 115 зохицуулалттай этгээд үйл ажиллагаа явуулж буй бөгөөд үүнд арилжаа эрхлэх 2, төлбөр, тооцоо, хадгаламжийн 1, хөрөнгө оруулалтын менежментийн 9, брокер дилерийн 61 компани, хөрөнгө оруулалтын зөвлөх 16 компани, давхардсан тоогоор андеррайтерийн тусгай зөвшөөрөлтэй 24, кастодиан үйлчилгээ үзүүлэх арилжааны 3 банк тус тус байна.

Үнэт цаасны зах зээлийн төлбөр, тооцооны үзүүлэлтүүд

“Монголын хөрөнгийн бирж” ХК-д хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлснээс хойш төвлөрсөн хадгаламжид өссөн дүнгээр нийт шинээр 811.7 мянга, холболтоор 136.1 мянган данс нээгдсэн байна. Нийт дансыг бүтцээр нь үзвэл, 807.2 мянган дотоодын иргэн, 1866 гадаадын иргэн, 2496 дотоодын аж ахуйн нэгж, 177 гадаадын аж ахуйн нэгжийн данс тус тус байна. Тайлант хугацаанд үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид нийт 5040 данс шинээр нээгдсэнээс 4999 нь дотоодын иргэн, 25 нь гадаадын иргэн, 15 нь дотоодын аж ахуйн нэгж, 1 нь гадаадын аж ахуйн нэгжийн данс тус тус байна. Нээгдсэн дансны тоог өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал 7.3 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Арилжааны бус хэлцэл болох өв залгамжлалын нийт 87 гүйлгээгээр давхардсан тоогоор 35 ХК-ийн 37.6 мянган ширхэг хувьцаа, бэлэглэлээр 4 гүйлгээ

хийгдэж, давхардсан тоогоор 9 ХК-ийн 24.9 мянган ширхэг хувьцааны өмчлөх эрхийг шилжүүлжээ.

Хөрөнгө оруулагчдын бүтцийн хувьд “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн арилжаанд дотоодын иргэн 9 хувь, дотоодын аж ахуйн нэгж 88 хувь, гадаадын аж ахуйн нэгж 1 хувь, гадаадын иргэн 2 хувийг тус тус эзэлж байна. Мөн хугацаанд хувийн хөрөнгө оруулалтын сангийн 1 компанийн 48 тэрбум төгрөгийн нэгж эрхийг бүртгэсэн ба өссөн дүнгээр 2 хувийн хөрөнгө оруулалтын сангийн 98 тэрбум төгрөгийн нэгж эрх бүртгэгдээд байна. Үнэт цаасны зах зээлд хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 2 компанид шинээр олгож, өссөн дүнгээр 9 компани үнэт цаасны зах зээлд тухайн үйл ажиллагааг эрхэлж байна.

ДААТГАЛЫН БАЙГУУЛЛАГА

Даатгалын салбарын ерөнхий мэдээлэл

Ерөнхий төлөв байдал

2016 оны эхний улирлын байдлаар ердийн даатгалын 15, урт хугацаат даатгалын 1, ХАА-н давхар даатгалын компани 1, нийт 3454 даатгалын мэргэжлийн оролцогч уг зах зээлд оролцож байгаагаас зуучлагч 37, хохирол үнэлэгч 29, 3105 төлөөлөгч Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрөл, зөвшөөрлийн үндсэн дээр үйл ажиллагаа эрхэлж байна.

Хүснэгт 2.7

Даатгалын салбарын тусгай зөвшөөрөл, эрх эзэмшигчдийн тоо

Үзүүлэлт	2013	2014	2015	2016Q1
Даатгагч	17	17	16	16
Даатгалын төлөөлөгч	3 178	3 260	3 340	3 105
Даатгалын зуучлагч	20	30	37	37
Даатгалын хохирол үнэлэгч	14	20	27	29
Дүн	3 253	3 342	3 691	3 454

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

Даатгагчийн хөрөнгө

2016 оны эхний улирлын байдлаар даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулж буй даатгалын компанийн нийт хөрөнгийн хэмжээ 159.6 тэрбум төгрөг байгаагаас 60.2 тэрбум төгрөг буюу 38.0 хувийг дүрмийн сан, 33.8 тэрбум төгрөг буюу 21.0 хувийг нөөц сан эзэлж байна. Дүрмийн сангийн 47.7 хувь нь банкны хадгаламжид, 3.9 хувь нь үнэт цаасанд байршуулсан хөрөнгө оруулалт, 20.2 хувь нь үндсэн хөрөнгө, 11.5 хувь нь банкны харилцах, 11.4 хувь нь бусад хөрөнгөд тус тус байршиж байна.

Сүүлийн 5 жилд даатгалын салбарт үйл ажиллагаа явуулж буй нийт компаниудын хөрөнгийн хэмжээ 2.7 дахин нэмэгдсэн бол урт хугацааны даатгалын үйл ажиллагаа эрхэлж буй цор ганц компани болох “Нэйшнл лайф даатгал” ХХК-ны хөрөнгийн

хэмжээ 5.7 дахин тус тус нэмэгдсэн дүнтэй байна.

Хүснэгт 2.8

Даатгалын компаниудын нийт хөрөнгийн хэмжээ (2015 оны IV улирлын байдлаар, тэрбум төгрөг)

№	Даатгалын компаниуд	Нийт хөрөнгийн хэмжээ	Эзлэх хувь
1	Монгол даатгал ХХК	27.9	16.1%
2	Тэнгэр даатгал ХХК	12.7	7.3%
3	Бодь даатгал ХХК	11.0	6.4%
4	Миг даатгал ХХК	10.4	6.0%
5	Мандал женерал даатгал ХХК	9.8	5.7%
6	Соёмбо даатгал ХХК	9.3	5.4%
7	Практикал даатгал ХХК	9.0	5.2%
8	Ард даатгал ХХК	8.8	5.1%
9	Номин даатгал ХХК	8.3	4.8%
10	Нэйшнл лайф даатгал ХХК	7.6	4.4%
11	Хаан даатгал ХХК	5.8	3.3%
12	Монре даатгал ХХК	5.8	3.4%
13	УБ хотын даатгал ХХК	5.7	3.3%
14	Ган зам даатгал ХХК	5.7	3.3%
15	Гэр даатгал ХХК	5.0	2.9%
16	Мөнх даатгал ХХК	4.3	2.5%
17	ХАА-н давхар даатгал	26.1	15.0%
	Дүн	173.2	100.0%

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.


Нийт даатгалын компаниудын хөрөнгийн 82.9 хувийг эргэлтийн хөрөнгө, 17.1 хувийг эргэлтийн бус хөрөнгө, эх үүсвэрийн 46.7 хувийг өр төлбөр, 53.3 хувийг эзэмшигчдийн өмч тус тус эзэлж байна.

Даатгагчийн өр төлбөр ба эзэмшигчдийн өмч

Даатгалын нөөц сан нийт өр төлбөр эзэмшигчдийн өмчид 2012 онд 44.5 хувь, 2013 онд 46.5 хувь, 2014 онд 43.4 хувь, 2015 онд 42.7 хувь, 2016 оны эхний улирлын байдлаар 34.9 хувь тус тус байгаа нь даатгалын компаниудын нөөц сан буурах хандлагатай байгааг харуулж байна.

Дүрслэл 2.31

Даатгалын компаниудын өр төлбөр,
эзэмшигчдийн өмч



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

Даатгалын хураамжийн орлого ба нөхөн төлбөр

Даатгалын салбарын нийт хураамжийн орлогын хэмжээ 2016 оны эхний улирлын байдлаар 26.9 тэрбум төгрөгт хүрлээ. Энэ өмнөх оны мөн үеэс 23 хувиар буурсан үзүүлэлт юм. Нийт даатгасан зүйлийн үнэлгээний 28.2 хувийг барилга угсралтын, 20.7 хувийг агаарын хөлгийн, 20.7 хувийг агаарын хөлгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой хариуцлагын, 14.5

хувийг хөрөнгийн, 7.0 хувийг гэнэтийн осол, эмчилгээний даатгал тус тус эзэлж байгаа бөгөөд дээрх 5 даатгалын хэлбэр нь даатгалын зүйлийн 91.2 хувийг бүрдүүлж байна.

2005 оноос 2014 он хүртэлх хугацаанд нийт хураамжийн орлого 99.2 тэрбум төгрөгөөр ялангуяа 2012 оноос эхлэн огцом өссөн байна. Үүнд 2012 онд “Жолоочийн даатгалын тухай хууль” батлагдаж, хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор албан журмаар даатгуулах даатгуулагчдын тоо нэмэгдэж, мөн түүнчлэн албан журмын даатгалын өсөлтийг дагаж авто тээврийн хэрэгслийн даатгал өндөр өсөлттэй гарсан нь голлон нөлөөлжээ.

Даатгалын салбарын ашигт ажиллагаа

Салбарын хэмжээнд хураамжийн орлого 27.2 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеийнхээс даруй 23.0 хувиар буурсан хэдий ч цэвэр ашгийн хэмжээ 3.5 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 13 дахин өссөн үзүүлэлттэй байна. Салбарын цэвэр ашгийн хэмжээ ийнхүү өсөхөд үйл ажиллагааны зардал өмнөх оны мөн үеийнхээс буурсан нь голлон нөлөөлөв.

ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГА

Зээлийн батлан даалтын сан нь эргэлтийн хөрөнгийн, хөрөнгө оруулалтын, бичил зээлийн гэсэн 3 төрлөөр батлан даалтын үйл ажиллагаа эрхэлж байна. 2016 оны эхний улирлын байдлаар нийт 407 аж ахуй нэгж, иргэнд 72.8 тэрбум төгрөгийн зээлийн багцад 30.0 тэрбум төгрөгийн батлан даалтыг гаргасан. Сангаас гаргасан батлан даалтын дээд хэмжээ 500 сая төгрөг, доод хэмжээ 1 сая төгрөг байв.


Зээлийн батлан даалтын сан нь 12 банк, 8 банк бус санхүүгийн байгууллага, 1 ХЗХ-той хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж байгаагаас 9 банкаар дамжуулан батлан даалтын үйлчилгээг хүргэсэн. Нийт гаргасан батлан даалтын 24.6 хувийг Голомт банк, 20.9 хувийг Хас банк, 14.7 хувийг Хаан банк, 18.4 хувийг Төрийн банк, 12.5 хувийг Капитал банк, 8.1 хувийг Худалдаа хөгжлийн банкны зээлэнд тус тус гаргасан байна. 2016 оны эхний улирлын байдлаар зээлийн батлан

даалт гаргахаар шийдвэрлэсэн зээлийн тоо өмнөх оны мөн үеийнхээс 83.3 хувиар, батлан даалтын дүн нь 84.0 хувиар тус тус буурсан нь банкуудын зээлийн хязгаарлалт болон төсөл хөтөлбөрийн зээл олголтын хэмжээ буурсантай шууд холбоотой юм.

Нийт батлан даалтын 24.0 хувь нь ҮХААЯ-ны төсөл, 29.2 хувь нь банкны, 24.3 хувь нь ЖДҮХС-ийн төсөл, 22.5 хувь нь бусад эх үүсвэртэй зээл олголтод гаргажээ.

Дүрслэл 2.32

Батлан даалт гаргасан байдал болон санхүүжилтийн эх үүсвэр (сая төгрөг)



■ Батлан даалтын хэмжээ

№	Санхүүжилтийн эх үүсвэр	Батлан даалтын тоо	Батлан даалтын хэмжээ	Батлан даалттай түүнийн хэмжээ
1	Өрхийн бичиг үйлдвэрлэлийг дэмжих сан	3	37	74
2	Банк	141	8 772	20 785
3	БХБЯ-ны төсөл	1	250	1 000
4	Жайка	33	4 309	10 000
5	ЖДҮХС-ын төсөл	90	7 294	17 662
6	ҮХААЯ-ны төсөл	67	7 183	18 488
7	ХЭДС	50	140	269
8	Монгол 888 төсөл	11	1 572	3 633
9	НХДҮХС	9	412	769
10	АХБ-ны ажлын байр нэмэгдүүлэх төслийн зээл	2	21	60
	Дүн	407	29 993	72 768

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

ХӨДӨӨ АЖ АХУЙН БИРЖ БА ТҮҮХИЙ ЭДИЙН АРИЛЖАА

“Хөдөө аж ахуйн бирж” ХХК дээр тайлант хугацаанд 5400 тонн ноолуур, 26260 тонн хонины ноос, 710 тонн тэмээний ноос, 94300 тонн ямааны завод ноос, 11 тонн завод ноос, 16 тонн бодын хөөврийг нийт 21.3 тэрбум төгрөгөөр арилжигдсан ба түүхий эдийн бэлтгэл үе хараахан эхлээгүй байсан нь арилжааны хэмжээ доогуур байхад нөлөөлжээ.

Хүснэгт 2.9

Хөдөө аж ахуйн бирж дээрх түүхий эдийн арилжааны үнийн дүн

Барааны нэр	Барааны хэмжээ /тонн/	Арилжааны дүн /тэрбум төгрөг/
Ямааны ноолуур	5 400.0	3.1
Хонины ноос	26 260.0	4.3
Тэмээний ноос	710.0	0.4
Ямааны завод ноос	94 300.0	13.5
Завод ноос/тэмээ, хонины/	11.0	0.0
Бодын хөөвөр	16.0	0.0
Дүн	126 697	21

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

САНХҮҮГИЙН САЛБАРЫН ДЭД БҮТЭЦ, ТҮҮНИЙ ИНСТИТУЦИ

3.1 ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИНД ГАРСАН ӨӨРЧЛӨЛТ

Санхүүгийн тогтвортой байдлын тайлангийн 6 дахь дугаар гарснаас хойш Монгол Улсын санхүүгийн салбарын эрх зүйн орчныг сайжруулах, санхүүгийн тогтвортой байдлыг хангах чиглэлээр дараах хууль, журмууд батлагдлаа.

Ирээдүйн өв сангийн тухай хууль:

- ♦ Улсын Их Хурлаас Ирээдүйн өв сангийн тухай хуулийг 2016 оны 2 дугаар сарын 5-ны өдөр баталсан. Тус хууль нь нөхөн сэргээгдэхгүй эрдэс баялгаас төсөвт төвлөрүүлсэн орлогыг өнөө ба хойч үеийнхэнд тэнцвэртэй хуваарилах зарчмыг хэрэгжүүлэх зорилгоор Ирээдүйн өв санг байгуулах, түүнд хөрөнгө төвлөрүүлэх, сангийн өгөөжийг хуваарилах, сангийн хөрөнгийг удирдах бүтэц, зохион байгуулалтыг тогтоох, үйл ажиллагааг тайлагнах болон хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулах зорилготой. Уг хууль 2017 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөгдөнө.

Ирээдүйн тэтгэврийн нөөц сангийн тухай хууль:

- ♦ Улсын Их Хурлаас Ирээдүйн тэтгэврийн нөөц сангийн тухай хуулийг 2016 оны 2 дугаар сарын 5-ны өдөр баталсан. Тус хуулиар тэтгэврийн шинэчлэлийг эрчимжүүлэх зорилгоор ирээдүйн тэтгэврийн нөөц сан байгуулах, түүний хөрөнгийг бүрдүүлэх, удирдах, зарцуулах,

гүйцэтгэлийг нь тайлагнах, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулсан.

Төв банк /Монголбанк/-ны тухай хууль:

- ♦ Ирээдүйн өв сангийн тухай хууль 2016 оны 2 дугаар сарын 5-ны өдөр батлагдсантай холбоотойгоор Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан Монголбанкны зүгээс мөнгөн хөрөнгийг нь хуримтлуулан хадгалах, төлбөр тооцоо хийх, зээлийн үйл ажиллагаа эрхлэхийг нь үл хориглосон этгээдэд Ирээдүйн өв санг нэмж оруулсан байна.

Орон сууцны ипотекийн санхүүжилтийн журам:

- ♦ Монголбанкны Ерөнхийлөгчийн 2016 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн А-67 дугаар тушаалаар батлагдсан бөгөөд уг журмаар Ирээдүйн тэтгэврийн нөөц сангийн тухай хууль, Засгийн газар, Монголбанкны хамтран хэрэгжүүлж буй “Орон сууцны санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бий болгох” хөтөлбөр, Засгийн газар, Монголбанкны хооронд 2013 оны 4 дүгээр сарын 13-ны өдөр байгуулсан “Ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бий болгох талаар хамтран ажиллах харилцан ойлголцлын санамж бичиг”, Засгийн газрын 2016 оны 3 дугаар сарын 4-ний өдрийн 137 дугаар тогтоолоор батлагдсан “Ипотекийн зээл, санхүүжилтийн ерөнхий

журам”-ыг тус тус үндэслэн орон сууцны санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бий болгох хөтөлбөрийн хүрээнд олгох орон сууцны ипотекийн зээлийн санхүүжилт,

банкны орон сууцны ипотекийн зээлийн үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулна.

3.2 ТӨЛБӨР ТООЦОО, ХӨРӨНГИЙН БҮРТГЭЛИЙН СИСТЕМ

Их дүнтэй төлбөр тооцооны систем

Төлбөрийн системийн оролцогч хоорондын их дүнтэй төлбөр тооцоог Монголбанкны Банксүлжээ системээр бодит цагийн горимоор гүйцэтгэж байгаа нь төлбөр тооцооны системийн эрсдэлийг бууруулах, мөнгөн урсгалыг бодит цагаар хянах, мөнгөний бодлогын хэрэгжилтийг сайжруулах, заавал байлгах нөөцийг хангуулах боломжийг бүрдүүлдэг.


Их дүнтэй төлбөр тооцооны системээр банк хоорондын төлбөр тооцоо, Сангийн яамны Төрийн сангийн газрын төлбөр тооцоо, Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төвийн төлбөр тооцоог нэг бүрчлэн бодит цагаар гүйцэтгэж, үр дүнг тооцож байна. Түүнчлэн бага дүнтэй болон картын төлбөр тооцооны системийн үр дүнгийн тооцооллыг оролцогчийн Монголбанкн дахь харилцах дансанд тусгадаг.

Сүүлийн дөрвөн жилийн байдлаар төлбөрийн системээр хийгдэж буй нийт төлбөр

тооцооны дүнгийн 98 хувь, тооны 6-7 орчим хувь их дүнтэй төлбөр тооцооны системээр дамжиж байгаагаас үзэхэд энэхүү систем нь санхүүгийн зах зээлийн дэд бүтцийн тогтвортой байдлыг хангахад нэн чухал ач холбогдолтой болох нь харагдаж байна. Тайлант хугацаанд нэг өдөрт дунджаар 165 тэрбум төгрөгийн, 5 мянган ширхэг их дүнтэй гүйлгээ хийгдсэн үзүүлэлттэй байна.

Дүрслэл 3.1

Их дүнтэй төлбөр тооцооны системийн нэг өдрийн дундаж үзүүлэлт



Эх сурвалж: Монголбанк

Бага дүнтэй төлбөр тооцооны систем


Үндэсний цахим гүйлгээний төв нь банк хоорондын болон Сангийн яамны Төрийн сангийн газрын бага дүнтэй төлбөр тооцоо, банк хоорондын картын төлбөр тооцоог бодит цагийн горимоор дамжуулж, үр дүнгийн тооцооллыг цэвэршүүлэн, Банксүлжээ систем рүү дамжуулж, харилцах дансанд тусгадаг.

Сүүлийн дөрвөн жилийн байдлаар бага дүнтэй төлбөр тооцоо нь төлбөрийн системийн нийт гүйлгээний дүнгийн 2 орчим хувийг, харин гүйлгээний тооны 93-94 хувийг тус тус эзэлж байна. Олон тооны хэрэглэгчийн төлбөр тооцоог хамарч байдаг энэхүү системийн найдвартай, тасралтгүй ажиллагааг хангах нь харилцагчийн банкинд

итгэх итгэлийг хадгалах, ингэснээр санхүүгийн системийн тогтвортой байдалд нөлөө үзүүлэх ач холбогдолтой юм.

Дүрслэл 3.2

Бага дүнтэй төлбөр тооцооны системийн нэг өдрийн дундаж үзүүлэлт




Эх сурвалж: Монголбанк

Төлбөрийн систем

Дүрслэл 3.3

Картын гүйлгээний нэг өдрийн дундаж үзүүлэлт



Эх сурвалж: Монголбанк

Үндэсний төлбөрийн системийн найдвартай, тасралтгүй, үр ашигтай ажиллагааг хангаж, олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлэх чиг үүргийн дагуу Монголбанк нь шинэ дэвшилтэт төлбөрийн хэрэгслийг нэвтрүүлэх замаар бэлэн бус төлбөр тооцоог дэмжиж, эрх зүйн орчинг бүрдүүлэн ажиллаж байна.

Монгол Улсын төлбөрийн системийг хөгжүүлэх стратегийн бодлогын баримт бичгийг шинэчлэх, хууль эрх зүйн орчныг сайжруулах, төлбөрийн системд тавих хяналтын чадавхыг бэхжүүлэх үндсэн зорилгын хүрээнд Монголбанк нь Дэлхийн банкнаас техник туслалцааг авч эхэлсэн бөгөөд үүний үр дүнд Монгол Улсын төлбөрийн системийн дунд хугацааны (2016-2020) стратегийн баримт бичиг болон Үндэсний төлбөрийн системийн хуулийн төслийг боловсруулж, эрх бүхий бусад байгууллагуудтай хамтран ажиллаж байна. ҮЦГТ нь 2016 оны 1 дүгээр улирлын байдлаар нэг өдөрт дунджаар 5 тэрбум төгрөгийн 32.5 мянган ширхэг бага дүнтэй гүйлгээ, 6.1 тэрбум төгрөгийн 137.4 мянган ширхэг картын гүйлгээг тус тус дамжуулсан байна.

Төлбөрийн системийн хяналт

Монголбанкнаас үндэсний мөнгөн тэмдэгтэд итгэх олон нийтийн итгэл, санхүүгийн тогтвортой байдалд дэмжлэг үзүүлэх зорилгоор төлбөрийн системийн найдвартай, үр ашигтай ажиллагааг хангуулж, системийн оператор, оролцогчийн үйл ажиллагаанд хяналт тавин ажиллаж байна. Түүнчлэн төгрөг буюу үндэсний мөнгөн тэмдэгтийг орлох төлбөрийн бусад хэрэгслийг Монголбанкны зөвшөөрлөөр төлбөр тооцоонд хэрэглэхээр заасан Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн холбогдох заалтын дагуу төлбөрийн хэрэгслийн зөвшөөрлийг олгон ажиллахын зэрэгцээ оператор болон оролцогчийн мөрдөн ажиллавал зохих журам, зааврыг боловсруулж байна.

Олон улсын төлбөр тооцооны банкны Төлбөр тооцооны системийн хороо болон Үнэт цаасны хороодын олон улсын байгууллагын теникийн зөвлөлөөс тодорхойлон гаргасан

"Санхүүгийн зах зээлийн дэд бүтцийн зарчмууд"-ын хэрэгжилтийг хэрхэн хангагдаж байгааг тодорхойлж, хэрэгжилтийн түвшинг ахиулж, тогтмол хангуулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор Их дүнтэй төлбөр тооцооны системийн үнэлгээг хийж гүйцэтгэлээ.

Төлбөрийн системийн тасралтгүй, найдвартай ажиллагааг хангах зорилгод нийцүүлэн үнэт цаасны төлбөр тооцоо болон их дүнтэй төлбөр тооцооны "Банксүлжээ" систем, Свифт сүлжээний тасралтгүй ажиллагааны тайланг 14, Үндэсний цахим гүйлгээний төвийн хариуцаж буй төлбөрийн картын нэгдсэн сүлжээний болон бага дүнтэй төлбөрийн системийн тасралтгүй ажиллагааны тайланг 7, Худалдаа хөгжлийн банкнаас дэд гишүүн банкуудын тасралтгүй ажиллагааны тайланг 7 хоногийн давтамжтайгаар тус тус гаргуулан авч, хяналт тавин ажиллаж байна.

3.3 САНХҮҮГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Төвбанкны тухай хууль болон Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл (Зөвлөл)-ийн ажиллах дүрэмд заасны дагуу Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь түүний ээлжит болон ээлжит бус хуралдаан юм. Ээлжит хуралдааныг улирал бүр урьдчилан тогтсон товын дагуу хуралдуулдаг бол ээлжит бус хуралдааны хувьд цаг үеийн шинжтэй асуудлыг хэлэлцэх зорилгоор, аль нэг талын санаачлагаар тухай бүр зохион байгуулдаг болно.

Санхүүгийн тогтвортой байдлын тайлангийн өмнөх дугаар хэвлэгдэж олон нийтийн хүртээл болсноос хойшхи хугацаанд Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл нь

урьдчилан тогтсон товын дагуу 2016 оны 1 дүгээр сарын 14, 5 дугаар сарын 31-ний өдөр тус тус ээлжит хуралдаанаа хийлээ.

Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн 2016 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн хуралдаанаар: (i) Инфляцийн төлөв байдлын тайлан; (ii) Активын удирдлагын тогтолцоо, зээлийн хоёрдогч захыг хөгжүүлэх талаар банкуудтай хамтран ажиллах тухай; (iii) Үндсэн хуулийн цэцийн тогтоолтой холбоотойгоор үл хөдлөх хөрөнгийн барьцааны эрх зүйн зохицуулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай; (iv) Санхүүгийн мэдээллийн албаны мэдээлэл; (v) Гадаад валютын дотоодын захын тойм; (vi)

СТБЗ-ийн Ажлын албаны мэдээлэл; (vii) Монгол Улсын Санхүүгийн тогтвортой байдлын тайлан: Дугаар №6 (viii) 2015 онд хэлэлцсэн асуудлын хэрэгжилтийн тайлан; (ix) Ажлын албаны 2016 онд хийх ажлын ерөнхий чиглэлийн тухай; (x) Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн 2016 оны хуралдааны товыг тогтоох тухай зэрэг асуудлыг авч хэлэлцсэн.

Харин 2016 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн хуралдаанаар: (i) “Монгол Улсын Үндэсний төлбөрийн системийн хөгжлийн стратеги”-ийг батлах тухай; (ii) ЗГҮЦ-ны журмыг шинэчлэн батлуулах Ажлын хэсгийг байгуулах тухай; (iii) “Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр”-ийн явц болон хөтөлбөртэй холбоотой зарим зардлыг 2017 оны улсын төсвийн төсөлд тусгуулах тухай; (iv) Гадаад валютын дотоод захын тойм 2016 оны 5 дугаар сарын байдлаарх мэдээлэл (v) Инфляцийн төлөв байдлын тайлан 2016 оны 1 дүгээр улирлын байдлаарх мэдээлэл (vi) Засгийн газраас хэрэгжүүлж буй “Сайн малчин”, “Сайн оюутан”, “Сайн хашаа” хөтөлбөрүүдийн талаарх товч мэдээлэл (vii) “Үндэсний хөдөлгөөн”-ий Иргэний хуулийн 218.1 дэх хэсэгтэй холбоотой шаардлага, Валютын зохицуулалтын тухай болон Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай Монгол Улсын хуулиудын хэрэгжилтийн тухай танилцуулгыг УИХ-д хүргүүлэх зэрэг асуудлын талаар хэлэлцэв. Хуралдаанаас гарсан шийдвэрийн дагуу Зөвлөлийн гишүүд хариуцсан чиглэлээр тодорхой үүрэг даалгавар өгч, холбогдох газруудад санал, зөвлөмж хүргэн ажиллаж байна.

Санхүүгийн системийн эрсдэлийн үнэлгээ хийх, макро бодлогуудын харилцан уялдааг хангах, макро зохистой бодлогыг

хэрэгжүүлэх ажлын хүрээнд санал боловсруулах, Монгол Улсын Санхүүгийн тогтвортой байдлын тайланг хагас жил тутам бэлтгэн, олон нийтэд хүргэх үүрэгтэй, байнгын үйл ажиллагаатай нэгж бий болгохоор шийдвэрлэсний дагуу Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн Ажлын алба (СТБЗАА)-ыг Монголбанкинд төвлөрүүлж, 5 хүний орон тоотойгоор ажиллуулж байна.

СТБЗАА нь Монголбанк, Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хорооны холбогдох газруудтай хамтран ажиллаж, тайлан мэдээллийг хүлээн авч, “Монгол Улсын Санхүүгийн тогтвортой байдлын тайлан”-гийн эхний зургаан дугаарыг нэгтгэн боловсруулж, хэвлүүлэн, Монголбанкны цахим хуудаст байршуулж, олон нийтийн хүртээл болгосон бөгөөд ийнхүү долоо дахь дугаарыг та бүхэнд хүргэж байна.